



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР

2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ
2024 ОН

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР

БАТАЛСАН АЛБАН ТУШААЛТНЫ
ГАРЫН ҮСГИЙН ТАЙЛАЛ

ТАНИЛЦСАН:
ГАЗРЫН ДАРГА

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ, ТАЙЛАН
АХЛАХ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



С.ТӨМӨРДУЛАМ

Б.МӨНХБАЯР



М.ГАЧМАА

АГУУЛГА

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН	5
1.1. Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт	5
1.2. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнасан байдал	7
ХОЁР. ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН	8
2.1. Хууль тогтоомж тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн мэдээ.....	8
2.2. Нийслэлийн Засаг даргын захирамжийн хэрэгжилт.....	9
2.3. Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар асуудал танилцуулж, шийдвэрлүүлсэн талаар	16
2.4. Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн дээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт	17
2.5. Нийслэлийн Засаг даргаас Засгийн газрын гишүүд, салбарын сайд нартай байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилт.....	17
2.6. Улсын онцгой комиссоос өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт	18
ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	19
3.1. Байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүргийн хэрэгжилт	19
3.1.1. Барилга, дэд бүтцийн салбарын төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх .	19
3.1.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг зохион байгуулах.....	31
3.2. Хүний нөөцийн бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт	36
3.3. Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа	41
3.4. Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт	42
3.5. Шүүх хяналтын байгууллагад төлөөлөл хэрэгжүүлж ажилласан талаар	43
3.6. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	43
3.7. Дотоод хяналт шалгалт, хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын талаар	45
ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ	45
4.1. Мэдээллийн ил тод байдал, хэвлэл мэдээлэл	45
4.2. Хүний нөөцийн ил тод байдал	47
4.3. Төсөв, санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдал.....	47
4.4. Шилэн дансны мэдээлэл.....	48
ТАВ. БУСАД МЭДЭЭЛЭЛ	48
5.1. Цаг үеийн шинжтэй олон нийтийн ажлын талаар	48
ЗУРГАА. ДҮГНЭЛТ, САНАЛ	51

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2025 оны 06 дугаар сарын 25

Улаанбаатар хот

УДИРТГАЛ

Хотын стандартыг боловсруулж батлуулах, барилга дэд бүтцийн салбарт хяналт тавих зэрэг өргөн цар хүрээтэй чиг үүргийг хэрэгжүүлдэг Хотын стандарт, хяналтын газрыг Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 81 дүгээр тогтоол, нийслэлийн Засаг даргын 2024 оны А/430 дугаар захирамжийн дагуу өөрчлөн байгуулж, хотын стандартыг боловсруулж батлуулахтай холбоотой чиг үүргийг өөр байгууллагад шилжүүлж, барилга дэд бүтэц, орчны аюулгүй байдлын чиглэлээр төрийн хяналтын чиг үүргийг дагнан хэрэгжүүлж эхэлсэн нь тус газрын 2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд гарсан голлох өөрчлөлт байв.

2024 оны эхний улиралд хотын стандартын 19 төслийг боловсруулж, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд, иргэд аж ахуйн нэгжүүдээс санал авах, 3 хотын стандартад нэмэлт өөрчлөлт оруулж Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах, хотын стандартыг батлуулж мөрдүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулах журмын төсөл боловсруулах, “Тохижилт, бүтээн байгуулалтын жил”-ийн хүрээнд хотын стандартыг мөрдүүлэх, сургалт, сурталчилгааны олон талт ажлыг зохион байгуулсан байна.

Төрийн хяналт шалгалтын чиг үүргийн хувьд нийслэлийн Засаг даргын захирамж, газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран барилга угсралт, тохижилт бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд хууль тогтоомж, стандарт, нормыг мөрдүүлэх, гарч буй зөрчил, орчны аюулгүй байдлыг нэгдсэн байдлаар арилгуулах томоохон ажлуудыг зохион байгуулав.

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах чиг үүргийн хувьд комиссын үйл ажиллагааг төлбөртэй болгох асуудлаар зардлын хэмжээг барилга байгууламжийн төвөгшил, хэмжээг харгалзан тогтоох талаар тооцоо гаргаж шийдвэрийн төслийг Барилга, хот байгуулалтын яаманд уламжилж, нийслэлийн Засаг даргын 2024 оны А/503 дугаар захирамжаар комиссын бүрэлдэхүүнийг шинэчилж төлөөллийн тоог бууруулан төрийн үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад түргэн шуурхай үзүүлж байна.

БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

ЭРХЭМ ЗОРИЛГО: Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилтын хүрээнд хот байгуулалт, барилга, дэд бүтцийн салбарт хэрэгжих бүтээн байгуулалт, ашиглалт засварын ажил, үйлчилгээнд хууль тогтоомж, үндэсний болон хотын стандарт, нормыг мөрдүүлж, төрийн хяналт шалгалтын үр нөлөөтэй байдлыг сайжруулах нь тус газрын эрхэм зорилго болно.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ: Барилга, хот байгуулалт, дэд бүтэц, газрын харилцаа, уг салбарт орчны аюулгүй байдлыг хангуулах хүрээнд төрийн хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлж, иргэн, хуулийн этгээдээс


гаргасан өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, холбогдох хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт, техникийн зохицуулалт, үндэсний болон хотын стандартын хэрэгжилтэд хяналт тавина.

Газрын дүрмийг Нийслэлийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн А/654 дүгээр захирамжаар шинэчлэн батлуулж, дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж эхэллээ. Үүнд:

- барилга, хот байгуулалт, дэд бүтцийн салбарын төрийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх;
- хууль тогтоомж, стандарт, норм, дүрмийг мөрдүүлэхэд төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг мэдээлэл, сургалт, арга зүйгээр хангах, зөвлөн туслах, сурталчлан таниулах;
- барилга, дэд бүтцийн салбарын хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн баримт бичиг, үндэсний болон хотын стандарт, норм дүрмийн хэрэгжилтийн байдлыг судалж, эрсдэлийн үнэлгээ хийх;
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Хяналт шалгалт хийх нийтлэг журмын дагуу төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион байгуулж, түүний үр дүнд илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг авах;
- нийслэлийн хэмжээнд баригдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах чиг үүргийг хэрэгжүүлэх;
- барилга байгууламж, их засвар тохижилтын ажлыг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах;
- барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлтийг баталгаажуулах;
- ашиглалтад орсон барилга байгууламжийн талаарх мэдээллийг нэгтгэн, холбогдох мэдээллийн санг баяжуулах.

ГАЗРЫН БҮТЭЦ, ОРОН ТОО: Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн “Хяналт шалгалтын газрын бүтэц орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай” А/596 дугаар захирамжаар тус газар нь 6 нэгж, 98 хүртэлх орон тоог баталснаас 2024 оны эхний хагас жилийн байдлаар нийт 49 албан хаагчдын бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Схем 1. Газрын бүтэц, зохион байгуулалт



НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

1.1. Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт

Улс, нийслэлийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт газрын чиг үүрэгт хамаарах 6 төрлийн бодлогын баримт бичигт тусгагдсан нийт 15 зорилтын 28 арга хэмжээг хяналтад авч, хэрэгжүүлж ажилласан. Үүнд:

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээний ангилал	Хамаарах арга хэмжээний тоо						Нийт:
		Алсын хараа-2050	Шинэ сэргэлтийн бодлого	НЗДУАМХ	НХТЖҮЧ	Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө	Нийслэлийн 2021-2024 оны стратеги төлөвлөгөө	
1	Хотын стандартын тогтолцоог хөгжүүлэх	2	1	2	5	-	-	10
2	Төрийн хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах	1	-	-	1	2	-	4
3	Хууль тогтоомж, стандарт, нормыг мөрдүүлэх	1	1	3	2	4	3	14

Дээрх зорилт арга хэмжээний хэрэгжилтийг дараах байдлаар хураангуйлав.

1. Хотын стандартын тогтолцоог хөгжүүлэх

Тус газар нь 2024 оны эхний улирлын байдлаар хотын стандартын тогтолцооны хүрээнд бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан дараах арга хэмжээг хэрэгжүүлжээ.

а/ Барилга, дэд бүтцийн салбарт хамаарах хотын 19 стандартын төслийг боловсруулсаны дотор бодлогын баримт бичгийн зорилт арга хэмжээ болон тусгагдсан дараах стандартын төслүүдийг боловсруулж, холбогдох мэргэжлийн байгууллага, иргэд олон нийтээс санал авч, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахад бэлэн болсон. Үүнд:

- Алсын хараа-2050 баримт бичигт тусгагдсан “Эрчим хүчний хэмнэлттэй амьны орон сууцны жишиг зураг төсөл”,
- Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан
 - “Нийслэлийн ундны усны эх үүсвэрийн хамгаалалтад тавигдах шаардлага”,
 - “Хөв цөөрөм үүсгэх болон хур тундасны усыг хуримтлуулах, дахин ашиглахад тавигдах шаардлага”,
 - “Хот доторх оршуулгын газрын орчны эрүүл аюулгүй байдлын ерөнхий шаардлага” хотын стандарт.

б/ Хотын стандартын тогтолцоог хөгжүүлэх, хэрэгжилтийг хангуулах үндсэн цогц харилцааг зохицуулах “Хотын стандартыг батлуулах, хэрэгжилтийг зохион

байгуулах журам”-ын төслийг тус тус боловсруулж холбогдох мэргэжлийн байгууллагуудын саналыг авч нэгтгэн нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахад бэлэн болгосон.

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын бүтэц, чиг үүрэгт өөрчлөлт орсноор хотын стандартын чиг үүрэг 2024 оны 04 дүгээр сарын 01-ээс эхлэн шинээр зохион байгуулагдсан Хотын байгуулалт, хотын стандартын газарт шилжих болсоноор дээрх ажлыг тус газар үргэлжүүлэн хэрэгжүүлэхээр болсон.

2. Төрийн хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах:

Барилга, дэд бүтцийн салбарын хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах хөтөлбөрийн суурь судалгааг гүйцэтгэж байна. Үүнд:

- Хууль, эрх зүй: Барилга, дэд бүтцийн салбарт оролцогчдын хариуцлагыг нэмэгдүүлэх, төрийн хяналт шалгалтын чадавхыг сайжруулах зорилгоор хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн хүрээнд судалгаа хийж, нийт 9 хууль тогтоомжийн 21 зүйл заалтад нэмэлт, өөрчлөлт оруулахаар санал боловсруулав.
- Хүний нөөцийг дадлагажуулах, чиглүүлэх багц сургалт: Хяналтын улсын байцаагч нарыг нэгдсэн сургалт, арга зүйгээр хангах, салбарын хууль тогтоомжийн мэдлэгийг дээшлүүлэх хүрээнд сургалтын хөтөлбөрийг боловсруулж, 2024 оны 05 дугаар сарын 27, 28-ны өдрүүдэд Нийслэлийн Хүний нөөцийн хөгжлийн төв, Нийслэлийн Прокурорын газар, Авлигатай тэмцэх газартай хамтран мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулж нийт 76 улсын байцаагчийг хамруулсан.

3. Стандарт, норм мөрдүүлэх арга хэмжээ:

Нийслэлийн хэмжээнд иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллах, амьдрах нөхцлийг бүрдүүлэх зорилтын хүрээнд барилга, дэд бүтцийн салбарын бүтээн байгуулалтын бүхий л үе шатанд хууль тогтоомж, дүрэм журам, стандарт нормыг мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн дараах ажлуудыг зохион байгуулав. Үүнд:

- 2024 оныг “Тохижилт-Бүтээн байгуулалтын жил” болгон зарласантай холбогдуулан хотын стандартыг мөрдүүлэх, сурталчлан таниулах, хяналт шалгалтын үйл ажиллагаанд хамтран ажиллах талаар нийслэлийн нутгийн захиргааны 26 байгууллагатай уулзалт зохион байгуулж нийт 266 албан хаагч оролцсон байна.
- Иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад батлагдсан хотын стандартыг сурталчлан таниулах, хэрэгжилтийг хангуулах зорилгоор дүүргүүдтэй хамтран нийслэлд үйл ажиллагаа эрхэлж байгаа СӨХ-дын 478 төлөөлөл, худалдаа үйлчилгээ эрхлэгч 184 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллийг хамруулж сургалт зохион байгуулав.
- Нийслэлийн Засаг даргын 2024 оны “Хууль тогтоомж, хотын стандартыг мөрдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” А/367 дугаар захирамжийн хүрээнд хотын гол магистрал зам дагуух нийтийн эзэмшлийн зам талбайд хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангуулах 5 дэд ажлын хэсгийн хүрээнд хяналт шалгалт зохион байгуулж, 39 байршилд

орчны хог хаягдал болон хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулж, 43 байршилд барилгын түр хашааг стандартын дагуу солиулж, худалдаа, үйлчилгээний 72 байгууллагын гадна хаягийг хотын стандартын дагуу шинэчлэн сайжруулж, өнгө үзэмжгүй 80 гадна хаяг, зар сурталчилгааны байгууламжийг буулгав.

- Газрын даргын баталсан 2024 оны “Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” 02-13-01/023/01 дугаартай удирдамжийн хүрээнд барилга угсралтын ажил гүйцэтгэж буй нийт 227 иргэн, ААНБ-уудын үйл ажиллагаанд хяналт тавьж барилгын түр хашааг стандартад нийцүүлэх, орчны аюулгүй байдлыг хангуулах, барилгын хог хаягдлыг цэвэрлэж ачуулах, ХАБЭА-ын шаардлагыг хангуулах талаар хугацаатай үүрэг даалгавар өгч гүйцэтгэлийг шалгаж байна. Уг ажлын хүрээнд зөвшөөрөлгүй барилга 21, нийтийн эзэмшлийн зам талбайг хашаалсан, орц гарц чөлөөлж нийтийн эзэмшил болгох шаардлагатай 38 байршлын судалгааг гаргасан.
- Барилга байгууламжийг ашиглалтад оруулах тухай захиалагч аж ахуйн нэгж, иргэдийн нийт 519 хүсэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу судалж, 163 барилга байгууламж, 136 гадна цахилгаан хангамж, гэрэлтүүлэг, 76 барилга байгууламжийн их засвар, шинэчлэлт, тохижилтын ажлыг ашиглалтад оруулах үйл ажиллагааг зохион байгуулж, захиалагч, гүйцэтгэгч байгууллагуудад зөвлөн туслаж арга зүйгээр хангаж ажилласан.

1.2. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнасан байдал

Улс, нийслэлийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт газрын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээг газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан **“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”**-ын дагуу улирал, хагас жил тутам хэрэгжилтийг нэгтгэн газрын даргын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцэж Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тайлагнан ажиллаж байна.

Хүснэгт 1. 2024 оны эхний хагас жилийн хэрэгжилт, хувь

№	Бодлогын баримт бичиг	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилт:	
				1-р улирал	2-р улирал
1	“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого	1	4	75%	100%
2	“Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөр	1	2	70%	90%
3	Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	4	5	62%	75%
4	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	4	8	67.5%	-
5	Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө	4	6	43.3%	58.3%
6	Нийслэлийн 2021-2024 оны стратеги төлөвлөгөө	1	3	98.5%	-
Нийт:		15	28	69.3%	

Дараах бодлогын баримт бичгүүдийн оны эхний хагас жилийн хэрэгжилтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт хугацаанд нь хүргүүлэв. Үүнд:

- Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хагас жилийн биелэлтийг 2024 оны 05 сарын 16-ны өдөр ERP-Хяналт шинжилгээ үнэлгээ системээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тайлагнав.
- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тус газрын чиг үүргийн хүрээнд хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, үйл ажиллагааны хэрэгжилтийн тайланг 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 01/226 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэв.
- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэв.

ХОЁР. ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

2.1. Хууль тогтоомж тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн мэдээ

Дээд газраас ирүүлсэн тогтоол, шийдвэрийг газрын даргад танилцуулан цохолт хийлгэж, Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын дагуу бүртгэл-хяналтын карт хөтлөн хариуцан шийдвэрлэх нэгж, албан хаагчдад шилжүүлж, шийдвэрийг хяналтад авч хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Хяналтад авсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу сар, улирал бүр хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, даргын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт тайлагнаж байна.

2024 оны эхний хагас жилийн байдлаар хяналтад авсан 37 тогтоол шийдвэрийн нийт 50 заалтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд нэгдсэн дүнгээр 82.4 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 2. 2024 оны эхний хагас жилийн хэрэгжилт

Агуулга	Бүгд	Үүнээс:						
		Ерөнхийлөгчийн зарлиг	Монгол Улсын Засгийн газрын тогтоол	Монгол Улсын Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	Монгол Улсын Ерөнхий сайдын албан даалгавар	Нийслэлийн Засаг даргын захирамж	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдааны тэмдэглэл	Нийслэлийн онцгой комиссын албан даалгавар
Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо	37	1	3	4	1	23	4	1
Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо	50	1	4	4	1	27	11	2

Үүнээс	Биелсэн 90-100	33	1	2	3	1	22	3	1
	Хэрэгжих шатанд								
	70	8	-	1	-	-	2	4	1
	50	2	-	-	-	-	1	1	-
	30	3	-	1	-	-	-	2	-
	Хугацаа болоогүй	2	-	-	1	-	1	-	-
Тасарсан	1	-	-	-	-	-	-	1	-
Биелэлтийн дүн /хувь/		82.4%	90%	75%	73%	100%	91.4%	68%	80%

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу газрын үндсэн үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг сар бүр нэгтгэж Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт тайлагнаж байна.


2.2. Нийслэлийн Засаг даргын захирамжийн хэрэгжилт

Хагас жилийн байдлаар нийслэлийн Засаг даргаас батлагдсан нийт 40 захирамжийн хүрээнд газрын чиг үүрэг хамаарах үйл ажиллагааг зохион байгуулж хэрэгжилтийг хангуулж ажиллав. Чиг үүргийн хүрээнд 5 захирамж батлуулж, захирамжаар байгуулагдсан нийт 25 ажлын хэсгийн бүрэлдэхүүнд газрын удирдлага томилогдон ажилласан байна.

Хүснэгт 3. Нийслэлийн Засаг даргаар батлуулсан захирамж

Д/д	Огноо	Дугаар	Захирамжийн нэр
1.	2024.01.03	A/02	Ажлын хэсэг байгуулах тухай
2.	2024.03.26	A/309	Захиргааны актыг түр түдгэлзүүлэх тухай
3.	2024.03.26	A/310	Ажлын хэсэг байгуулах тухай (Олд консракт ХХК)
4.	2024.04.03	A/367	Хууль тогтоомж, хотын стандартыг мөрдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай
5.	2024.05.03	A/503	Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүн шинэчлэн батлах тухай

График 1. Ажлын хэсэгт ажилласан тоон мэдээлэл /2021-2024.06/



Нийслэлийн Засаг даргын “2024 оныг Тохижилт-Бүтээн байгуулалтын жил” болгон зарлах тухай А/01 дүгээр захирамжийн хэрэгжилт:

Тохижилт-Бүтээн байгуулалтын жил болгон зарласантай холбогдуулан 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрөөс 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрүүдэд Боловсрол, соёл шинжлэх ухааны яам болон нийслэлийн нутгийн захиргааны нийт 26 байгууллагатай уулзалт зохион байгуулж, бүтээн байгуулалтын зураг төсөлд хотын стандартын хэм хэмжээг тусгах, баталгаажуулах, тохижилтын ажилд зөвлөмж арга зүйгээр хангах, сургалт зохион байгуулах, хяналт шалгалтын үйл ажиллагаанд хамтран ажиллаж байна.




Зураг/ Байгууллагуудтай хийсэн уулзалт

1. Тохижилт бүтээн байгуулалтын ажилд хүндрэл учруулж буй хууль, дүрэм журмын судалгаа: Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч П.Сайнзориг даргын баталсан “Тохижилт бүтээн байгуулалтын ажил гүйцэтгэхэд хүндрэл учруулдаг, хөрөнгө оруулалтын ажлыг удаашруулж зогсоосон хууль, дүрэм журмын талаар судалж, шинэчлэн боловсруулах” дэд ажлын хэсгийн нарийн бичгээр ажиллаж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Амгалан ахлаж ажилласан. Дэд ажлын хэсгийн хуралдааныг 2 удаа зохион байгуулж, тохижилт бүтээн байгуулалтын ажлын өнөөгийн байдал, холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулахаар талаар ажлын хэсгийн гишүүдийн саналыг нэгтгэн боловсруулсан. Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 15 хууль, 4 тогтоол, 13 норм ба дүрэм нийт 32 эрх зүйн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулахаар 7 байгууллагаас санал ирүүлсэн.



Зураг/ Ажлын хэсгийн эхний хуралдаан



Зураг/ Ажлын хэсгийн хоёрдугаар хуралдаан

Байгууллагуудаас ирүүлсэн дээрх саналуудад дүн шинжилгээ хийж, хамаарал бүхий зүйл заалтуудыг ангилан ялгаж тохижилтын ажилд саад болж буй хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулснаас Барилгын тухай хуульд 1 санал, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд 2 санал боловсруулж Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Д.Амгалан даргад танилцуулж, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/01 дүгээр захирамжаар байгуулагдсан ерөнхий ажлын хэсэгт хүргүүлэв.

2. Сургалт, арга зүйгээр хангах ажлын хүрээнд: Тохижилт бүтээн байгуулалт, барилга угсралтын ажил эхэлж байгаатай холбогдуулан хотын стандартыг сурталчлан таниулах, барилга байгууламжийн ашиглалтыг сайжруулах, хийн хэрэглээний аюулгүй байдлыг хангах, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор газрын даргын баталсан “Барилга байгууламжийн ашиглалт, хотын стандартын хэрэгжилтийг хангуулах тухай” сургалтын хөтөлбөрийн хүрээнд 2024 оны 3, 4 дүгээр сард нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж буй нийт **478** СӨХ болон иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын төлөөллийн хамруулан сургалт зохион байгуулж арга зүйгээр хангаж ажиллалаа. Үүнээс:

- Хан-Уул дүүрэг - 25,
- Сонгинохайрхан дүүрэг - 46
- Баянгол дүүрэг - 114,
- Чингэлтэй дүүрэг - 58,
- Баянзүрх дүүрэг - 150,
- Налайх, Багануур, Багахангай дүүрэг - 42 иргэн хамрагдсан байна.



Сургалтын үеэр СӨХ-дын төлөөллүүдээс тулгамдаж буй асуудлын талаар барилгын, дэд бүтцийн хяналтын улсын /ахлах/ байцаагчид хууль тогтоомж, стандарт нормын талаар зөвлөмж мэдээлэл өгч ажиллалаа.

2. Стандарт, норм, дүрмийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд: Хяналт шалгалтын газраас нийслэлийн нутгийн захиргааны байгууллага болон ашиглалт хариуцсан байгууллагуудтай 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр уулзалт зохион байгуулж, гэрэлтүүлгийн ашиглалт, угсралтын үйл ажиллагааг нийслэлийн хэмжээнд хариуцан ажиллаж буй нийт 17 аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагууд, 6 дүүргийн гэрэлтүүлэг хариуцсан мэргэжилтнүүд оролцлоо.



Уулзалтаар дараах ажлуудыг хийж хэрэгжүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:

- Өнгө үзэмжгүй, эвдэрч гэмтсэн, эзэн холбогдогч тодорхойгүй шонгийн судалгааг гаргах;
- Нийслэлийн нутаг дэвсгэрт байгаа өнгө үзэмжгүй, эвдэрч гэмтсэн, эзэн холбогдогч тодорхойгүй шонг буулгаж, зөрчлийг арилгуулах үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулах;
- Стандарт норм дүрмийг шинэчлэн сайжруулах талаарх саналыг авч холбогдох байгууллагад уламжлан хүргүүлэх;
- Зураг төсөвт, ажлын даалгавар боловсруулахад, угсралтын ажил гүйцэтгэхэд, ашиглалтад хүлээн авахад болон комисс хүлээн авсны дараах ашиглалтын үе шатанд батлагдсан стандартыг мөрдүүлэх талаар хариуцсан чиглэлийн хүрээнд хяналт тавьж хамтран ажиллахад онцгой анхааран, гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусгах.

Хууль норм, дүрэм стандартын хэрэгжилтийг хангаж ажиллах тухай 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 01/355 дугаартай мэдэгдлийг нийт 17 аж ахуй нэгж байгууллагад хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/157 дугаар захирамжийн хэрэгжилт:

Улаанбаатар хотын инженерийн дэд бүтцийн нэгдсэн хяналт, удирдлагын цогц систем “UB-ENGINEERING”-ийн төсөл хэрэгжүүлэгчдийн төлөөлөл, ажлын хэсгийн хуралд 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдөр оролцож, тус нэгдсэн системд ашиглалтад орсон барилга байгууламжийн орон зай, талбарын мэдээлэл болон

барилга байгууламж, дэд бүтцийн хяналт шалгалтын түүхчилсэн мэдээллийг байгуулах, эрсдэлийг үнэлэх орон зайн дэд систем үүсгэх талаар санал боловсруулж 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 02/206 дугаартай албан бичгээр Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд хүргүүлэв.



Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/226 дугаар захирамжийн хэрэгжилт:

Нийслэлийн мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд мал орж ирснээр ногоон байгууламж, авто зам, нийтийн эзэмшлийн гудамж талбайг бохирдуулж, улмаар малын гоц халдварт өвчин дамжин тархах эрсдэл үүсгэж байгаа тул иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, мал, амьтны гаралтай гоц халдварт өвчин тархахаас урьдчилан сэргийлэх, хориглосон бүсээс мал гаргах арга хэмжээний хүрээнд 2024 оны 03 дугаар сарын 09, 10-ны өдрүүдэд ажиллаж хуваарийн дагуу Баянгол дүүргийн 7, 8, 13, 32 дугаар хороонд самналт хийж хориглосон бүсэд нэвтэрсэн малыг цагдаагийн албан хаагчдад мэдэгдэж хүлээлгэн өгөв.



Нийслэлийн Засаг даргын 2024 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/310 дугаар захирамжийн хэрэгжилт:

Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороо, Зайсангийн аманд “Олд констракшн” ХХК-ийн гүйцэтгэсэн Астра вилла хотхоны С блокийн барилгын чанар, аюулгүй байдал, батлагдсан зураг төслийн дагуу баригдсан эсэхэд барилгын техник, хот төлөвлөлт, эрчим хүч (цахилгаан, дулаан), өргөх байгууламж, ус хангамж, ариутгах татуургын хяналтын нийт 6 чиглэлээр төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай удирдамж

гарган 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрөөс эхлүүлж “Олд констракшн” ХХК-д захирамжийг танилцуулж, хяналт шалгалт хийх тухай мэдэгдэх хуудас хүргүүлсэн.



Зураг/ Хяналт шалгалтын үеэр

Гүйцэтгэгч “Олд констракшн” ХХК нь ашиглалтад оруулаагүй барилга байгууламжид айл оруулсан байгаа нь Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дэх заалт, Зөрчлийн тухай хуулийн 12.1 дүгээр зүйлийн 1.11 дэх заалт хэсгийг зөрчсөн үндэслэлээр хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, 2024 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр зөрчлийн хэрэг нээж 5.000 /таван мянган/ нэгжийн торгууль ногдуулж, нүүж орсон айлуудыг чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтны хугацаатай албан даалгавар хүргүүлсэн. Торгуулийн төлбөрийг барагдуулсан боловч эрх бүхий албан тушаалтны албан даалгаврыг хугацаанд нь биелүүлээгүй тул Монгол Улсын Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан биелүүлэх захирамж, гүйцэтгэх хуудас гаргуулахаар 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 01/145 дугаартай албан бичгээр Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хүргүүлсэн.

Нийслэлийн Засаг даргын 2024 оны “Хууль тогтоомж, хотын стандартыг мөрдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” А/367 дугаар захирамжийн хэрэгжилт:

Нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, иргэдийн эрүүл аюулгүй орчинд ажиллах, амьдрах орчныг бүрдүүлэх зорилгоор төвийн гол магистрал шугам дагуу нийтийн эзэмшлийн зам талбайд холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, норм, стандартын хэрэгжилтийг хангуулах, зөрчлийг газар дээр нь шуурхай арилгуулах 5 дэд ажлын хэсэг байгуулагдаж нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын нийт 130 албан хаагч оролцсоноос тус газрын 25 албан хаагч оролцож хамтарсан хяналт шалгалтыг зохион байгуулсан. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулах хүрээнд иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад нийт 248 зөвлөмж, 172 мэдэгдэх хуудас, улсын /ахлах/ байцаагчийн 16 албан шаардлага хүргүүлж дараах арга хэмжээ авч ажилласан. Үүнд:

- Барилга угсралтын орчны аюулгүй байдлыг хангуулаагүй нийт 189 зөрчил илрүүлж, 39 байршилд орчны хог хаягдал болон хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулж, 43 байршилд барилгын түр хашааг стандартын дагуу солиулав.




- Худалдаа, үйлчилгээний байгууллагуудын гадна хаягийн стандарт хангуулаагүй, өнгө үзэмжгүй нийт 389 зөрчил илрүүлж, 203 газрын гадна хаягийг албадан буулгуулав.



- Нийтийн эзэмшлийн зам талбайн ил задгай холболттой нийт 399 гэрэлтүүлгийн шонг тагжуулж, 27 шонг тэгшлүүлж, 4370 метр сип кабелийг цэгцэлж, 204 шонг будаж өнгө үзэмжийн сэргээж, 2376 метр шилэн кабель буулгаж цэгцлүүлэв.




- Нийслэлийн хэмжээнд шатахуун, шингэрүүлсэн шатдаг хийн худалдаа эрхэлдэг 42 аж ахуйн нэгжийн 284 ШТС, 57 АХЦС-ын гадна орчны өнгө үзэмжийг сайжруулах талаар мэдэгдэл хүргүүлж, 94 ШТС, 16 АХЦС-ын гадна орчныг цэвэрлүүлэв.



2.3. Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар асуудал танилцуулж, шийдвэрлүүлсэн талаар

2024 онд газрын хариуцсан чиг үүргийн хүрээнд Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд 6 асуудал хэлэлцүүлэхээр төлөвлөснөөс 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 06 дугаар хуралдаанд “Барилгын гадна фасадын чанар стандарт, ашиглалтын өнөөгийн байдал”-ын талаар танилцуулж, шийдвэр гаргуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.



Зураг/ Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурал 2024.03.25



Зураг/ Үйлдвэрүүдэд шалгалт хийж буй явц

Хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын дагуу газрын даргын баталсан 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 02-13-01/023/08 дугаартай удирдамжийн хүрээнд Нийслэлийн Онцгой байдлын газартай хамтран барилгын гадна фасад, дулаан тусгаарлах материал /хөрсөн полистрол хавтан/ үйлдвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудад урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөс 04 сарын 05 дугаар сарын 31-ний өдрүүдэд хийж гүйцэтгэсэн.

Шалгалтад нийт 48 үйлдвэрийг хамруулж барилгын материалын салбарт мөрдөгдөж буй норм ба дүрэм, стандартыг мөрдүүлэх талаар улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлэв. Тусгай зөвшөөрөлгүй, тохирлын гэрчилгээгүй үйл ажиллагаа явуулж байсан 10 аж ахуйн нэгж, байгууллагад албан даалгавар хүргүүлж Зөрчлийн тухай хуулийн дагуу 50.0 сая төгрөгийн торгууль ногдуулав.

Нийслэлийн хэмжээнд барилгын гадна фасад, дулаан тусгаарлах материал үйлдвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллагын дунд 2024 оны 3 дугаар улиралд хэлэлцүүлэг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

2.4. Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн дээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт

Нийслэлийн удирдах ажилтнуудын 12 удаагийн шуурхай зөвлөгөөнөөс Нийслэлийн Засаг даргаас тус газарт нийт 59 үүрэг даалгавар өгөгдсөнийг тухай бүр хэрэгжилтийг бүрэн хангаж, биелэлтийг 14 хоног тутамд ERP-Хяналт шинжилгээ үнэлгээ дэд системээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт хугацаанд нь тайлагнаж ажилласан.

Хүснэгтээр үзүүлбэл:

Шуурхай хуралдааны тоо	Үүрэг даалгаврын тоо:		Биелэлтийн дундаж
	Нийт үүрэг даалгавар	Байгууллагад өгсөн	
12	353	59 (Үндсэн хэрэгжүүлэх-20)	86.6 хувь

2.5. Нийслэлийн Засаг даргаас Засгийн газрын гишүүд, салбарын сайд нартай байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилт

Газрын даргын 2024 оны “Гэрээний хэрэгжилтийг хангуулах тухай” А/07 дугаар тушаалаар Барилга, хот байгуулалтын сайдтай хамтран ажиллах гэрээний 16 заалтыг хэрэгжүүлэх 29 арга хэмжээ, Эрчим хүчний сайдтай хамтран ажиллах гэрээний 7 заалтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө баталж хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Хүснэгтээр үзүүлбэл:


Д/д	Салбар, чиглэл	Заалтын тоо	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт:	
				1-р улирал	2-р улирал
1.	Барилга, хот байгуулалтын сайдтай байгуулсан гэрээ	16	19	87.4%	93.8%
2.	Эрчим хүчний сайдтай байгуулсан гэрээ	7	7	88%	96.6%
Нийт:		23	26	87.7%	95.2%

Сайдуудтай байгуулсан гэрээний 2024 оны 1 дүгээр улирлын хэрэгжилтийг нэгтгэн, 2024 оны 04 дүгээр 02-ны өдөр газрын даргын дэргэдэх удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулсан. Хагас жилийн байдлаар Эрчим хүчний сайдтай байгуулсан гэрээний биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 01/184 дугаартай албан бичгээр, Барилга, хот байгуулалтын сайдтай байгуулсан гэрээний биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 01/243 дугаартай албан бичгээр тус тус Нийслэлийн Засаг даргын Тамгын газар хүргүүлэв.

2.6. Улсын онцгой комиссоос өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт

Улсын онцгой комиссын даргын 2024 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” 01 дүгээр тушаал, Улсын Онцгой комиссын нарийн бичгийн даргын баталсан удирдамжийн дагуу шатахуун, хий зэрэг тэсэрч дэлбэрэх аюултай бодисын хадгалалт, тээвэрлэлт, түгээлтийн үйл ажиллагаа нь стандарт, норм, дүрэм нь аюулгүй байдлын шаардлага хангаж байгаа эсэхэд 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрөөс 03 дугаар сарын 15-ны өдөр хяналт шалгалт хийж, дүн мэдээг Улсын Онцгой комисст хүргүүлэв. Үүнд:

1. Нийслэлийн нутаг дэвсгэрт газрын тосны бүтээгдэхүүний хадгалалт, түгээлт, тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг 41 аж ахуйн нэгжийн 22 шатахуун хадгалах агуулах, 284 шатахуун түгээх станц, 57 автомашин хийгээр цэнэглэх станц, 5 хий цэнэглэх станцын үйл ажиллагаанд шалгалт хийсэн. АХЦС-ууд ил сав ашиглаж байгаа нь хий алдагдсан тохиолдолд галын аюул осол үүсэх эрсдэлтэй бөгөөд аюулгүй зай хэмжээ зөрчиж хүүхдийн цэцэрлэг, худалдаа үйлчилгээний барилгатай ойр баригдсан байна.



Хот байгуулалтын мэдээллийн санд бүртгэгдээгүй 142 ШТС, АХЦС-уудыг байр зүйн зураг хийлгүүлж мэдээллийн санд оруулах мэдэгдлийг хүргүүлсэн. Хяналт шалгалт хийсэн танилцуулга, цаашид авах арга хэмжээний саналыг Улсын онцгой комиссын ажлын албанд 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 01/318 дугаартай албан бичгээр хүргүүлэв.

2. Аюултай ачаа тээврийн үйл ажиллагаа явуулж буй 17 аж ахуй нэгжийн 251 тээврийн хэрэгслийн техникийн шаардлага, тээвэрлэлтийн нөхцөлийг хангасан эсэхэд шалгалт хийж, “Автотээврийн тухай хууль”, “Автотээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэх дүрэм”, “Автотээврийн хэрэгслээр хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журам”-ын хэрэгжилтийг хангуулах тухай улсын /ахлах/ байцаагчийн 173 заалт бүхий 17 албан шаардлага хүргүүлэн ажиллалаа.



ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

3.1. Байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүргийн хэрэгжилт

3.1.1. Барилга, дэд бүтцийн салбарын төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх

Төрийн хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах хөтөлбөр

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 417, 469 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар татан буугдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” А/1649 дүгээр захирамжаар барилга, дэд бүтцийн 11 чиглэлээр төрийн хяналтын чиг үүргийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлж эхэлсэн.

Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг салбарын 27 хууль тогтоомж, 65 гаруй дүрэм журам, 423 орчим барилгын норм ба дүрэм /БНБД/, 826 гаруй үндэсний болон хотын стандартыг хэрэгжүүлэх хүрээнд хяналт шалгалтыг зохион байгуулж, 2023 онд нийт **4550** объект, 2024 оны эхний хагас жилд нийт **1143** объектыг хамруулсан байна.

Салбарын хэмжээнд мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилт, үүсэж буй хүндрэл бэрхшээлийг тодорхойлж нийслэл дэх төрийн хяналт шалгалтын үр дүн, үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор барилга, дэд бүтцийн хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах хөтөлбөрийг боловсруулахаар “Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд тусган дараах үндсэн 4 зорилтыг дэвшүүлэн боловсруулж байна. Үүнд:

- Төрийн хяналтын улсын байцаагч нарын хүний нөөцийн тогтвортой байдлыг хангуулж, хөгжүүлэх багц хөтөлбөр боловсруулах;
- Хяналт шалгалтын мэдээллийн системийг хөгжүүлэх, /хяналтад шаардлагатай мэдээллийн хүртээмжийг сайжруулах/;
- Хяналтын үр нөлөө, ажлын бүтээмжид сөргөөр нөлөөлж буй хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах;
- Хяналт шалгалтын зардал, хангамжийг сайжруулах.



Хөтөлбөрийн төслийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Барилга, дэд бүтцийн салбарын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Хяналт шалгалт хийх нийтлэг журмын дагуу төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг холбогдох яамдын салбарын хяналтын газрын удирдамж болон газрын даргын хяналт шалгалтын удирдамжийн хүрээнд зохион байгуулж, түүний үр дүнд илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг авч ажиллаж байна.


№	Салбар	Хяналтын чиглэл	Харьяа яамд
1	Барилга	Барилгын техник	Барилга, хот байгуулалтын яам
2		Хот төлөвлөлт	
3		Өргөх байгууламж	
4		Ус хангамж, ариутгах татуурга	
5		Барилгын материал	
6	Дэд бүтэц	Эрчим хүч (цахилгаан)	Эрчим хүчний яам
7		Эрчим хүч (дулаан)	
8		Авто зам	Зам тээвэр хөгжлийн яам
9		Авто тээвэр	
10		Газрын тос, хий	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
11		Харилцаа холбоо	Цахим хөгжил харилцаа холбооны яам

Хүснэгт. Хяналт шалгалтын тоон үзүүлэлт /Хагас жилийн байдлаар/

Хяналтын чиглэл	Хяналт шалгалтын төрөл			Өгсөн иргэн, ААНБ-ын тоо						Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа	Торгууль (сая.төг)	Нөхөн төлбөр (сая.төг)
	Төлөвлөгөөт (их, дүнд эрсдэлтэй)	Урьдчилан сэргийлэх	Төлөвлөгөөт бус (өргөдөл, гомдол)	Дүгнэлт	Зөвлөмж	Албан шаардлага	Шаардах хуудас	Албан бичиг	Танилцуулга			
Барилга	45	227	326	87	25	75	27	313	2	64	249.2	-
Дэд бүтэц	21	158	366	30	16	45	8	114	6	24	39.2	36.15
Нийт	66	385	692	117	41	120	35	427	8	88	288.4	

Хяналт шалгалтад хамрагдсан нийт объектын тоо: 1143

Улсын /ахлах/ байцаагчдын үйлдсэн эрх зүйн баримт бичгийн тоо
2024.06 сарын байдлаар



Нэг. Төлөвлөгөөт хяналт шалгалт

Барилга, дэд бүтцийн салбар чиглэлээр салбарын хяналтын <http://shilenkhyanal.gov.mn> цахим системд нийт 269 объектын эрсдэлийн үнэлгээг оруулж, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 79 дүгээр тогтоолоор баталсан “Салбарын хяналт шалгалтын төлөвлөгөө”-ний дагуу их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн нийт 66 объектод хяналт шалгалтын ажлыг зохион байгуулав.

1.1. Эрчим хүчний хяналтын чиглэлээр:

Эрчим хүчний яам Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр баталсан 11/02 дугаартай удирдамжийн дагуу Хяналт шалгалтын газрын эрчим хүчний хяналтын улсын /ахлах/ байцаагчид, боловсролын хяналтын улсын /ахлах/ байцаагч нартай хамтран 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдрөөс 04 дүгээр сарын 24-ний өдрүүдэд нийслэлийн хэмжээний нийт 20 сургууль, цэцэрлэгийн гадна болон дотор цахилгаан, дулаан хангамжийн инженерийн шугам сүлжээний ашиглалтын төлөв байдал, аюулгүй найдвартай ажиллагааг хангаж байгаа эсэхэд төлөвлөгөөт хяналт шалгалт хийсэн.



Зураг/ Илэрч буй зөрчил дутагдлууд

Сонгинохайрхан дүүргийн 105, 124-р сургууль, 117, 170, 55-р цэцэрлэг, Баянгол дүүргийн 47, 13, Оюуны ундраа сургуулиуд, 162, 86, 77, 161, 95, 96-р цэцэрлэг, Баянзүрх дүүргийн 61-р цэцэрлэг, Сүхбаатар дүүргийн 40-р цэцэрлэг, Хан-Уул дүүргийн 15-р сургууль, Чингэлтэй дүүргийн 56-р цэцэрлэг, 17, 49-р сургуулиуд нийт (12 цэцэрлэг, 8 сургууль) 20 объектын насжилт өндөртэй гадна болон дотор цахилгаан, дулаан хангамжийн инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжүүдэд үзлэг шалгалтыг зохион байгуулсан.

Хяналт шалгалтын явцад нийт 70 гаруй дутагдлыг илрүүлж, 28 дутагдлыг газар дээр нь арилгуулж, ашиглалтын үеийн норм, дүрмийн хэрэгжилтийг хангах, аюулгүй ажиллагаа болон техник ашиглалтын дүрмийг хэрэгжүүлэх, бичиг баримтын бүрдлийг хангаж ажиллах талаар мэргэжил арга зүйн зөвөлгөө өгч улсын ахлах байцаагчийн 11-13-02/052/04 дугаартай 16 заалт бүхий зөвлөмжийг 14 сургууль, цэцэрлэгт хүргүүлсэн. Шалгалтын үр дүнгийн талаар 2024 оны 05 дугаар сарын 28 өдрийн 11-13-02/052/01 дугаартай танилцуулга гарган цаашид авах арга хэмжээний саналын талаар Нийслэлийн онцгой байдлын газар, Нийслэлийн боловсролын газарт тус тус албан бичиг хүргүүлэв.

1.2. Авто зам, замын байгууламжийн хяналтын чиглэлээр:

Авто замын хяналтын чиглэлээр дараах 8 төсөл арга хэмжээнд төлөвлөгөөт хяналт шалгалт хийхээр төлөвлөсөн. Үүнд:

№	Шалгуулагч этгээдийн нэр	Объектын нэр	Замын урт
1	Мотор сервис ХХК	Наадамчдын авто замаас Энхтайвны өргөн чөлөө хүртэлх авто замын 391.55 у/м гүүр	391.55 у/м
2	Монгол зам групп ХХК	Сонгинохайрхан дүүрэг Толгойтын авто замыг Ард Аюушийн өргөн чөлөөтэй холбох авто зам	4.5км
3	ЗМЗ ХХК	Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороо, Зайсангийн 225 у/м гүүр	225 у/м
4	Тотал Инж ХХК	Наадамчдын авто замаас Энхтайваны өргөн чөлөө хүртэлх авто зам, замын байгууламжийн барилгын ажил нэгдүгээр хэсэг	2.3км
5	Ди Вай Кей Би ХХК	Гачууртын авто замаас Шархадны автобусны эцсийн зогсоол хүртэлх 4.27 км авто зам	4.27км
6	Туулын гүүр далай ХХК	Гачууртын авто замаас Шархадны автобусны эцсийн зогсоол хүртэлх Улиастайн гол дээрх 97.3 у/м төмөрбетон гүүр	97.3 у/м
7	Бумбат даваа ХХК	Голден парк орон сууцны хорооллын хойгуурх техник импортоос эрэлийн байр хүртэлх туслах замыг шинэчлэх /БГД, 5 дугаар хороо/ ажил	1км
8	Арж капитал ХХК	Хан-Уул дүүрэг 23-р хороо, Нүхтийн авто зам	1.2км

Хагас жилийн байдлаар Зам, тээврийн хөгжлийн яамны Салбарын хяналтын газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдөр баталсан “Төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай” 04/19 дугаартай удирдамжийн хүрээнд дараах 2 төсөл арга хэмжээ, авто зам шинэчлэлийн ажилд хяналт шалгалт хийсэн. Үүнд:

1. Хан-Уул дүүрэг 23 дугаар хороо, нүхтийн авто замын шинэчлэлийн ажлын зураг төсөл, барилга угсралтад шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн 1 албан шаардлага, 2 зөвлөмжийг захиалагч байгууллага Нийслэлийн Замын хөгжлийн газар, гүйцэтгэгч Арж капитал ХХК-д тус тус хүргүүлэн биелэлтийг хангуулан ажилласан. Тухайн авто замын газар шорооны ажил дууссан бөгөөд суурь хучилтын ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу дахин тендер зарлаж хийлгэхээр шийдвэрлэсэн байна.



2. Баянгол дүүргийн 5 дугаар хороо, Голден парк орон сууцны хорооллын хойгуурх Техник импортоос Эрэлийн байр хүртэлх туслах замыг шинэчлэх ажил нь инженерийн шугам сүлжээ шилжүүлж, хүчитгэх ажлаас шалтгаалан авто замын ажил эхлээгүй бөгөөд Авто замын тухай хууль, холбогдох норм, дүрмийг мөрдөж ажиллах талаар гүйцэтгэгч “Бумбат даваа ХХК”-д улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлэв.



1.3. Барилгын материалын хяналтын чиглэлээр:

Барилга хот байгуулалтын яам, салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 09 дугаартай төлөвлөгөөт шалгалт хийх тухай удирдамжийн хүрээнд 15 аж ахуйн нэгж байгууллагад хяналт шалгалт хийхээр төлөвлөснөөс 7 ААНБ-д хяналт шалгалт хийсэн. Үүнд:

- Их эрсдэлтэй үнэлэгдсэн 2 ААНБ-д 10.0 сая төгрөгийн торгууль ногдуулж, эрх бүхий албан тушаалтны албан даалгавар хүргүүлсэн.
- Дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 1 ААНБ-д улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.
- Бага эрсдэлтэй үнэлэгсэн 4 ААНБ-д хууль, стандарт, норм дүрмийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 02-13-01/040/03 дугаартай улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлэн ажиллалаа.

Хоёр. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт

2.1. Хяналт шалгалтын газрын даргын баталсан 2024 оны 02-13-01/023/01 дугаартай удирдамжийн хүрээнд:

Нийслэлийн хэмжээнд иргэд оршин суугчдад эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх, хууль тогтоомж, стандарт нормын хэрэгжилтийг хангуулах хүрээнд иргэдээс удаа дараа ирүүлж буй өргөдөл, гомдлыг барагдуулах, барилга угсралтын шатанд гарч буй зөрчил, орчны аюулгүй байдлыг нэгдсэн байдлаар арилгуулах зорилгоор дараах 6 чиглэлээр хяналт шалгалт хийх ажлын хэсэг байгуулагдаж, 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс 05 дугаар сарын 24-ний өдийн хооронд шалгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

1. Иргэдээс удаа дараа ирүүлж буй өргөдөл гомдлыг барагдуулах, орчны аюулгүй байдлыг нэгдсэн байдлаар хангуулах;
2. Барилга, байгууламж, шугам сүлжээний төлөвлөлт нь АТД, загвар зурагтай нийцэж буй эсэх;
3. Нийтийн эзэмшлийн зам талбайд тулгаж, эвдэж баригдсан зөвшөөрөлгүй барилга, барилгын хийцлэл /пандус, шат/-ийг буулгах;
4. Авто зогсоол хүрэлцэхгүй байгаа Төрийн болон олон нийтийн барилгуудын зогсоолыг нэмэгдүүлэх;

5. Нийслэлийн хэмжээний ШТС, АХЦС-уудын ариун цэврийн байгууламжийг стандартад нийцүүлэх;
6. Тээврийн товчоонуудад хяналт шалгалт хийж, тээвэрлэлтийн нөхцөл хангаагүй, бүтээлэг, татлагагүй том оврын тээврийн хэрэгслийг постоор нэвтрүүлэхгүй байх.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд нийт 53 албан хаагч ажилласнаас Хяналт шалгалтын газраас 34, Хот байгуулалт, хотын стандартын газраас 6, Цагдаагийн удирдах газраас 6, дүүргүүдийн Хөдөлмөр, халамжийн үйлчилээний хэлтсээс 7 албан хаагч ажиллаж арга хэмжээ авч ажиллав.



Барилга угсралтын ажил гүйцэтгэж буй нийт 227 иргэн, ААНБ-уудын үйл ажиллагаанд хяналт тавьж барилгын түр хашааг стандартад нийцүүлэх, орчны аюулгүй байдлыг хангуулах, барилгын хог хаягдлыг цэвэрлэж ачуулах, ХАБЭА-ын шаардлагыг хангуулах талаар хугацаатай үүрэг даалгавар өгсөн. Шалгалтаар нийт 442 зөрчил илрүүлж, 158 шаардах хуудас, 16 мэдэгдэх хуудас, 16 улсын /ахлах/ байцаагчийн албан шаардлага, 35 иргэн, хуулийн этгээдэд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг явуулж, 24 иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоож ажиллав.



Шалгалтын явцад илэрсэн зөрчлийн судалгааг нэгтгэж Нийслэлийн Засаг даргад танилцуулж холбогдох нутгийн захиргааны байгууллагуудад хүргүүлэхээр бэлтгэж байна. Үүнд:

- Буулгах барилга 21;
- Нийтийн эзэмшилд шилжүүлэх 38.

Гүйцэтгэлийн хяналтыг 2024 оны 06 дугаар сарын 25-ны дотор гүйцэтгэж, үр дүнг Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахаар төлөвлөж байна.

Иргэдэд ая тухтай орчныг бүрдүүлэх, хотын стандартыг мөрдүүлэхээр нийслэлийн хэмжээнд шатахуун, шингэрүүлсэн шатдаг хийн худалдаа эрхлэгч 42 аж ахуйн нэгж байгууллагад “Нийтийн бие засах газрын төлөвлөлт байгуулалтад тавих техникийн шаардлага”-ын дагуу нийтийн бие засах газрыг шинэчлүүлэх тухай 2024.04.25-ны өдрийн 01/546 дугаартай албан бичгээр улсын байцаагчийн мэдэгдэл хүргүүлж гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна.



Улаанбаатар хот орчмын “Таван толгой”, “Түргэний гол”, “Хоолт”, “Городок”, “Хонхор”, “Гүнт”, “Баруунтуруун”, “Эмээлт” нийт 8 автотээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх товчоодоор нэвтэрч буй автотээврийн хэрэгслүүдийн бүх жин стандартаар зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтэрсэн эсэх, барилгын материал, хог хаягдал тээвэрлэж буй тээвэрлэгч жолооч нар элс, хайрга, дайргыг асгарах, гээгдэх, нурахаас хамгаалан зориулалтын бүтээлэг, хашлага, өндөрлөгөө, татлага хэрэглэж буй байдалд болон Нийслэлийн төвийн 6 дүүрэгт төлбөртэй авто зогсоол ажиллуулж буй иргэн, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн.

Шалгалтаар дараах зөрчил дутагдал илэрч, зөрчлийг арилгах арга хэмжээ авч, улсын байгцаагчийн зөвлөмж хүргүүлэв. Үүнд:

- “Хоолт”, “Баруун туруун” товчоодын автотээврийн хэрэгсэл нэвтрэх хэсгийн автозамууд эвдэрсэн;
- “Түргэний гол”, “Баруун туруун” товчоодын автотээврийн хэрэгслийн бүх жинг шалгадаг пүү эвдэрсэн, “Хоолт” товчоон дээр шинээр суурилуулсан пүүг ашиглалтад оруулаагүй;
- Нийслэлийн төвийн 6 дүүрэгт төлбөртэй зогсоол ажиллуулж байгаа иргэн, аж ахуйн нэгжүүд нь эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулахгүйгээр ажиллаж байгаа зөрчлүүд илэрлээ.

“Хоолт”, “Түргэний гол”, “Баруун туруун” товчоодын авто замд үүссэн эвдрэл, “Түргэний гол”, “Баруун туруун” товчоодын автотээврийн хэрэгслийн бүх жинг шалгадаг пүү эвдэрснийг засварлуулах, “Хоолт”-ын товчоон дээр суурилуулсан пүүг ажилд оруулж, хяналт тавьж ажиллах талаар “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-т 01/146 дугаартай албан бичиг хүргүүлсэн. “Монголын үндэсний бетон үйлдвэрлэгчдийн холбоо” ТББ, “Элс, хайрга, дайрга үйлдвэрлэгч компаниудын холбоо” ТББ-уудад барилгын материал тээвэрлэлтийн нөхцөл, аюулгүй байдал, техникийн шаардлагыг хангаж ажиллах тухай, автозамын ажил захиалагч, гүйцэтгэгч иргэн, аж ахуйн нэгжид улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлэв.

2.2. Хот төлөвлөлтийн хяналтын чиглэлээр:

Барилга, хот байгуулалтын яамны Салбарын хяналтын газрын Улсын ерөнхий байцаагчийн 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 02-00/12 дугаартай удирдамжийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хэрэгцээ, шаардлагыг хангуулах зорилгоор нийт 84 объектын зураг төсөл, угсралт, ашиглалтын чанар аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийсэн. Барилга байгууламжийн орц, гарц, дотор зохион байгуулалт, гадна тохижилт нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зорчих, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангаж төлөвлөгдөж баригдсан эсэхийг шалгахад дараах гүйцэтгэлтэй байна.

Үүнд:

- Барилга угсралтын ажил гүйцэтгэж буй 56 объектоос хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээг хангуулсан-47, гүйцэтгэх шатандаа-9;
- Ашиглалтад орсон 23 объектоос хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээг хангуулсан-17, хангуулаагүй-6.

Хяналт шалгалтын явцад барилгын ажлын захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч иргэн, хуулийн этгээдэд хөгжлийн иргэдийн хүртээмжийг нэмэгдүүлэх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар улсын байцаагчийн зөвлөмж, мэдэгдэл хүргүүлэн ажиллаж байна.

2.2. Барилгын техникийн хяналтын чиглэлээр:

Газрын даргын баталсан 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02-13-01/025/03 дугаартай “Улс нийслэлийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй барилга байгууламж, орчны аюулгүй байдалд хяналт шалгалт хийх тухай” урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын удирдамжийн хүрээнд Барилгын хөгжлийн төв ТӨҮГ болон Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газраас нийслэлд 2024 онд он дамжин болон шинээр баригдах сургууль, цэцэрлэгийн төсөл хөтөлбөрийн судалгааг авсан. Нийт 215 төсөл арга хэмжээ хэрэгжиж байгаагаас 54 барилга байгууламжид мэдэгдэл хүргүүлж, баримт бичигт хяналт шалгалтыг хийж байна.

2.3. Ус хангамж, ариутгах татуургын хяналтын чиглэлээр:



Геодези усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ болон бусад албан хаагчдын хамт 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрөөс 03 дугаар сарын 05-ны өдрийн хооронд Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар дүүргүүдийн шар усны үер болох эрсдэлтэй Сэлбэ гол дагуу далан сувгуудад хяналт шалгалт хийж, тайлан мэдээг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.

Үерийн хамгаалалтын далан сувагт ил задгай хог хаягдал их хэмжээгээр хаяснаас хогны цэг үүссэн, далан сувгийн хамгаалалтын зурвас газарт газар эзэмших барилга барих, үйлчилгээ эрхлэх зэрэг зөрчил дутагдлууд түгээмэл илэрч байх тул дүүргүүдийн Засаг дарга нарт 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 02-13-02/041/04 дугаартай Улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлээд байна.



2.4. Өргөх байгууламжийн хяналтын чиглэлээр:

Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламж, концессын гэрээ, бусад эх үүсвэрээр хэрэгжиж буй төсөл хөтөлбөр, арга хэмжээ, хувийн хөрөнгө оруулалтын хүрээнд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 44 аж ахуйн нэгжид шалгалт хийж цамхагт кран-44, Барилгын өргүүр-27, Автокран-14, Гүүрэн кран-42, Бетон зуурмагын шахуургат төхөөрөмж-4 нийт 131 өргөх байгууламжид хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар 3 аж ахуйн нэгжид 12 заалт бүхий албан шаардлага, 41 аж ахуйн нэгжид 574 заалт бүхий зөвлөмж хүргүүлж осол гэмтлээс урьдчилан сэргийлж ажилласан.



Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх явцад дараах 5 байршилд осол гарах эрсдэлтэй өргөх байгууламжуудыг газар дээр нь таслан зогсоох арга хэмжээг авч ажиллаа. Үүнд:

№	Байршил	Илэрсэн зөрчил	Авсан арга хэмжээ
1	Баянзүрх дүүрэг, 10 дугаар хороо	Иргэн Т.Анхцэцэг, П.Пүрэвдорж, Ш.Отгон нарын захиалгатай 16 давхар орон сууцны барила угсралтад ашиглаж буй Zoomlion QY25V маркын автокраныг эргийн хажууд байрлуулсан.	Ажлыг зогсоож барилгын талбайгаас гаргасан.
2	Баянзүрх дүүрэг, 12 дугаар хороо	Уран хан апартамент хотхоны барилгад ашиглаж буй ZLP 630 маркын дүүжин өргүүрийг мэргэжлийн бус хүмүүс ажиллуулж байсан.	Зөрчлийн тухай хуулийн дагуу арга хэмжээ тооцов.
3	Баянзүрх дүүрэг, 16 дугаар хороо	Бүтээлч трейд ХХК-ийн барилга угсралтад ашиглаж буй SMZ маркын ачааны өргүүрийг буруу угсарсан.	Шаардах хуудас өгч газар дээр нь буулгуулах, засварлуулах арга хэмжээ авсан.
4	Баянзүрх дүүрэг, 38 дугаар хороо	Багант хорооллын 32 дугаар блокын барилгын кранаар хүн өргөж байсан.	Газар дээр нь зогсоож ЗТХ-ийн 5.15-1.3 дахь заалтын дагуу арга хэмжээ тооцов.
5	Баянзүрх дүүрэг, 38 дугаар хороо	Даацын цамхаг ХХК-ийн гүйцэтгэж буй 16 давхар орон сууцны барилгад ашиглаж буй ZLP-630 маркын дүүжин өргүүрийг буруу болон бүрэн бус угсарсан.	Зөрчлийг газар дээр нь зогсоож буулгуулах арга хэмжээ авсан.

2.5. Барилгын материалын хяналтын чиглэлээр:

Барилга, хот байгуулалтын яамны сайдын баталсан 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 87 дугаар тушаал, 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 96 дугаар тушаалын дагуу Импортоор орж ирсэн цементэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай удирдамж, Газрын даргын баталсан 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 02-13-01/023/08 дугаартай удирдамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд арматур импортлогч, үйлдвэрлэгч 15 аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлгүй, тохирлын гэрчилгээгүй 10 ААНБ-уудад зөрчлийн хэрэг бүртгэлийн ажиллагааг явуулж, 50.0 сая төгрөгийн торгууль тавьж, гүйцэтгэлийг хангуулах, ЭБАТ-ны зөрчил арилгуулах тухай албан даалгавар хүргүүлж, нийслэлийн Прокурорын газрын хяналтын Прокурорт хянуулж ажиллалаа.

2.6. Авто зам, замын байгууламжийн хяналтын чиглэлээр:

Зам, Тээврийн хөгжлийн яамны Салбарын хяналтын газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр баталсан 04/04 дугаартай Урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай удирдамжаар Намьянжугийн гуамж /Зүүн 4 замаас урагш Нарантуулын уулзвар хүртэл/, Амгалангийн авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт /Ботаникийн эцсээс Улиастайн гүүр хүртэл/-ийн 3 шинэчлэлийн ажилд шалгалт хийж, улсын байцаагчийн 04-13-02/040/04 дугаартай зөвлөмж хүргүүлэв.

2.7. Авто тээврийн хяналтын чиглэлээр:

Зам тээвэр хөгжлийн яамны Салбарын ерөнхий байцаагчийн баталсан "Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай" 04/02 дугаартай удирдамжийн дагуу нийслэлийн нутаг дэвсгэрт кузов засварын үйлчилгээ эрхэлж буй нийт 30 вьетнам засварын газрын үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх шалгалт хийж, 12 аж ахуйн нэгжид албан шаардлага хүргүүлж, Зөрчлийн тухай хуулийн дагуу 2 аж ахуйн нэгжид 1.000.0 төгрөгийн торгууль ногдуулж албан даалгавар хүргүүлэв.



Гурав. Төлөвлөгөөт бус хяналт шалгалт

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлт, гомдол, мэдээлэл, холбогдох яамдын Салбарын хяналтын газар болон газрын даргын баталсан нийт 22 удирдамжийн хүрээнд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж, хуулийн хугацаанд улсын байцаагчийн эрх зүйн баримт бичиг,

албан бичгээр хариуг хүргүүлэн ажиллаж байна. 2024 оны эхний хагас жилийн байдлаар барилга, дэд бүтцийн хяналтын чиглэлээр нийт **692** өргөдөл, гомдол, хүсэлтийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажиллав.

Зөрчлийн талаарх гомдол мэдээлэл, шалган шийдвэрлэх ажиллагаа


Зөрчлийн шинжтэй өргөдөл, гомдлыг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу судлан шийдвэрлэх, зөрчлийн хэргийг нээх, шийдвэрлэх ажиллагааг Нийслэлийн Прокурорын хяналтан дор явуулж байна. Улсын Ерөнхий Прокурорын 2021 оны А/77 дугаар тушаалаар батлагдсан “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн хэлбэрийн загвар, жагсаалт”-ын дагуу зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хуулийн хугацаанд зохион байгуулан 2024 эхний хагас жилийн байдлаар нийт 109 зөрчлийн гомдол, мэдээллийн бүртгэлийг хийж, тухай бүр хяналт тавих байгууллага буюу нийслэлийн Прокурорын газарт niislelprozurchil@gmail.com цахим хаягаар хүргүүлэн нэгдсэн бүртгэлд бүртгүүлэн ажилласан. Үүнээс:

- Зөрчлийн хэрэг нээсэн 11;
- Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн 81;
- Татгалзсан 5,
- Хэрэгсэхгүй болгосон 5.

Нийт 288.4 сая төгрөгийн торгууль, 36.1 сая төгрөгийн нөхөн төлбөр ноогдуулсан байна.

Тандалт судалгааны ажлын хүрээнд

Орон сууцны барилгад ашиглагдаж байгаа нийт 7354 лифтэнд насжилтийн судалгаа судалгааг 2024 оны байдлаар шинэчлэн гаргав.



Бүртгэл баталгаажуулалтад хамруулах ажлын хүрээнд

Аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Кран-13, Лифт-32, Эскалатор-0, Барилгын өргүүр-7, Манипулятор кран-7, Сагстай өргөгч-9, нийт 66 өргөх байгууламжийг улсын бүртгэлд шинээр бүртгэж мөн 24 лифтний улсын бүртгэлийг шинэчлэн нийт 90 өргөх байгууламжийг бүртгэсэн байна.

Авто тээвийн үндэсний төвийн Техникийн хяналтын үзлэгийн системд өргөх байгууламжийн тусгай зөвшөөрөлтэй ААН-үүд болон өөрөө явагч тээврийн хэрэгсэл дээр суурилсан өргөх байгууламжийн бүртгэл хийх ажлын хүрээнд өргөх байгууламжийн тусгай зөвшөөрөлтэй ААН- 76, өөрөө явагч тээврийн хэрэгсэл дээр суурилсан өргөх байгууламж-760-г бүртгэж нийт 816 бүртгэл, хөгжүүлэлтийг хийж байна.

Өргөх механизмын бүртгэл

Техникийн хяналтын үзлэгийн систем

Төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг мэдээлэл, сургалт, арга зүйгээр хангах ажлын хүрээнд

Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх газартай хамтран жижиглэнгээр савласан шингэрүүлсэн шатдаг хий худалдаалдаг худалдааны газруудын ажилтнуудад зориулсан “Шингэрүүлсэн шатдаг хийн баллонт тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа”, “220 граммаар савласан шингэрүүлсэн шатдаг хийн ахуйн хэрэглээ” сэдэвт сургалтыг 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдөр Номин холдинг ХХК-ийн 14 салбарын нийт 29 ажилтан, Дашваанжил ХХК-ийн инженер техникийн албаны 24 ажилтан, Дүнжингарав худалдааны төвийн цайны газрын 14 тогоочийг тус тус хамруулан зохион байгуулав.



Зураг. Сургалтын үйл явц

Барилга байгууламжийн ашиглалт, хотын стандартын хэрэгжилтийг хангуулах зорилгоор сургалтын хөтөлбөр батлуулж, нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж буй Сууц өмчлөгчдийн холбоо (СӨХ)-дод 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн зохион байгуулж, нийт 478 СӨХ, болон иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын төлөөллийн хамруулан зохион байгуулж зөвлөн туслан арга зүйгээр хангаж ажиллалаа.

3.1.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг зохион байгуулах

Монгол Улсын Засгийн засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/503 дугаар захирамжийн дагуу барилга байгууламж, түүний гадна талбайн тохижилт, засварлах, тоноглох ажлыг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, стандартын шаардлагад нийцүүлэн ашиглалтад оруулах үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.

Барилгын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан нийслэлийн хэмжээнд барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагаа зохион байгуулахад шаардагдах бичиг хэрэг, тээвэр шатахуун, харилцаа холбоо, хөгжлийн бэрхшээлтэй иргэний цалин, урамшуулал зэрэг үйл ажиллагааны зардлыг барилга байгууламжийн бага, дунд, өндөр төвөгшлийн ангиллаар тооцож судалгааг хийж санал боловсруулсан.

Уг саналыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатараас 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн “Санал хүргүүлэх тухай” 01/135 дугаартай албан бичгээр Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлэв. Тус яамнаас барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын ажиллах зардлын тооцоог барилга байгууламжийн төвөгшил, ангилалтай уялдуулан судалж, санал боловсруулах үүрэг бүхий ажлыг хэсэг байгуулахаар шийдвэрлэж, тус газраас ажлын хэсэгт ажиллах албан тушаалтны мэдээллийг 2024 оны 05 сарын 07-ны өдрийн 01/64 тоот албан бичгээр Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлэв.

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн барилга, байгууламж, гадна цахилгаан хангамж, барилга байгууламжийн гадна талбайн тохижилт, засварлах, тоноглох ажлыг ашиглалтад оруулах тухай хүсэлтийг www.e-mongolia.mn, www.e-business.mn, www.edoc.ulaanbaatar.mn цахим порталуудаар хүлээн авч ажлын 5-10 хоногт судлан шийдвэрлэж байна. Хагас жилийн байдлаар нийт **578** хүсэлтийг хүлээн авч судалж шийдвэрлэсэн байна.

№	Төрөл	Хүсэлтийн тоо
1	Барилга байгууламж	266
2	Гадна цахилгаан хангамж, гэрэлтүүлэг	214
3	Их засвар, шинэчлэлт, тохижилт	98
Нийт		578


Газрын даргын 2024 оны “Удирдамж, арга зүйгээр хангах тухай” А/09 дүгээр тушаалын дагуу барилга, байгууламж, гадна цахилгаан хангамж, барилга байгууламжийн гадна талбайн тохижилт, засварлах, тоноглох ажлыг ашиглалтад оруулахад бэлтгэл ажлыг хангуулж ашиглалтад оруулах хүсэлт ирүүлсэн нийт **113** барилгын ажлын гүйцэтгэлд урьдчилсан үзлэг хийж илтгэх хуудсаар газрын даргад танилцуулан баталгаажуулж комиссын хуваарьт тусгав.

Комисс ажиллах хуваарийг 7 хоног бүр боловсруулж Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч П.Сайнзориг

болон газрын даргаар батлуулан байгууллагын цахим хуудсанд байршуулан ажиллаж байна.

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг батлагдсан хуваарийн дагуу нийт **375** байршилд зохион байгуулснаас барилга байгууламж-163, гадна цахилгаа хангамж, гэрэлтүүлэг-136, барилга байгууламжийн их засвар, шинэчлэлт, тохижилт-76 ажил, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар захиалагч, гүйцэтгэгчдэд үүрэг даалгавар өгч ажиллав.

Комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хянаж барилга-130, цахилгаан хангамж-133, их засвар, тохижилтын ажил-70 дүгнэлт баталгаажуулж, 2024 оны эхний хагас жилийн байдлаар нийт **333** барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авсан байна.



Гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд Баянгол дүүрэгт-2, Баянзүрх дүүрэгт-5, Сонгинохайрхан дүүрэгт-1, Сүхбаатар дүүрэгт-3, Хан-Уул дүүрэгт-2 байршилд тус баригдсан орон сууцны барилгыг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан. Дээрх 14 төслийн хүрээнд нийт 1828 айлын орон сууц ашиглалтад орсон байна.


Үндэсний статистикийн хорооны дэд даргын 2021 оны А/01 дүгээр тушаалаар батласан Ашиглалтад орсон нийтийн зориулалттай болон амины орон сууцны байшингийн мэдээ маягт /А-ОС-1/, Ашиглалтын шаардлага хангахгүй буулгасан нийтийн зориулалттай болон амины орон сууцны байшингийн мэдээ маягт /А-ОС-2/-ын дагуу хагас, бүтэн жилээр тайлагнах ажлын хүрээнд ашиглалтад орсон нийтийн зориулалттай болон амины орон сууцны барилгын холбогдох 41 мэдээллийн талбар бүхий дэлгэрэнгүй мэдээллийг маягтын дагуу нэгтгэн боловсруулж Нийслэлийн статистикийн газарт хүргүүлсэн. Үүнд:

- 2023 онд ашиглалтад орсон 231 барилгын мэдээлэл;
- 2024 оны I улиралд ашиглалтад орсон 55 барилгын мэдээлэл.

Ашиглалтад орсон барилга байгууламжийн орон зайн мэдээллийн сан


Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллаж, дүгнэлт баталгаажсан барилга байгууламжийн орон зайн мэдээллийг QGIS системийн мэдээллийн санд хагас жилийн байдлар 6 төрөлт өгөгдлийн нийт 317 объектийн дэлгэрэнгүй мэдээллийг бүртгэн баяжуулалт хийн оруулсан байна. Үүнд:

- Орон сууцны барилга: 112,
- Олон нийтийн барилга: 55,
- Цахилгаан хангамж: 101,
- Шугам сүлжээ: 6,
- Их засвар, шинэчлэлт: 3,
- Тохижилт: 40.




Мэдээллийн санд бүртгэгдсэн барилга байгууламжийн төрөл

№	Төрөл	Тоо	Хувь
1	Үйлчилгээтэй орон сууц	38	31.4
2	Аялал жуулчилалын цогцолбор	17	14.04
3	Орон сууц	22	18.18
5	Сургууль, цэцэрлэг /цогцолбор/	4	3.3
6	Сургууль	2	1.6
7	Цэцэрлэг	5	4.1
8	Эмнэлэг	5	4.1
9	Бусад	28	23.1
Нийт		121	100%



Зураг. Барилга байгууламжийн дэд мэдээллийн сангийн өгөгдөл /Барилга/



Зураг. Барилга байгууламжийн дэд мэдээллийн сангийн өгөгдөл /Эрчим хүчний барилга/



Иж бүрдмэл дэд өртөө /КТПН/



Хаалттай дэд өртөө /ХТП/




Агаарын трансформаторын дэд өртөө /АТП/



Хуваарилах байгууламж /РП/



Гэрэлтүүлэг



Зураг. Барилга байгууламжийн дэд мэдээллийн сангийн өгөгдөл /засвар, тохижилт/



3.2. Хүний нөөцийн бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт

Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах хүрээнд 2024 оны “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг шинэчлэн боловсруулж 2 бүлгийн 13 арга хэмжээг төлөвлөн газрын даргаар 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдөр батлуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад тогтоомжийн хүрээнд албан хаагчдын томилох, чөлөөлөх, хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулах, сэлгэн ажиллуулах, шилжүүлэн ажиллуулах, албан тушаал дэвшүүлэх, албан тушаалаас түдгэлзүүлсэн нийт **55** тушаал шийдвэрийг тухай бүр боловсруулж, санал авч, батлуулан ажиллалаа. Үүнд:

- албан тушаалд томилсон, жинхлэн томилсон, дэвшүүлэн томилсон-12,
- албан тушаалаас чөлөөлсөн, гэрээг дуусгавар болгосон-4,
- нэгж хооронд шилжүүлсэн-2,
- байгууллага хооронд шилжүүлсэн-3,
- албан үүрэг гүйцэтгэхийг түдгэлзүүлсэн-1

Мөн тэтгэмж, хүүхэд асрах чөлөө, мэргэшлийн зэргийн нэмэгдэл, түр орлон гүйцэтгүүлэх, ажил хавсран гүйцэтгүүлэх, сахилгын шийтгэл ногдуулах тухай зэрэг тушаал шийдвэрүүдийг боловсруулав.

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагад ажиллаж буй хяналтын улсын байцаагч болон төрийн албаны тусгай шалгалт өгч нэр дэвшүүлэн шинээр томилогдох улсын байцаагч нарыг мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр бий болгох талаар тус газраас санаачилж, сургалтын агуулга, мөн тэтгэвэрт гарсан улсын ахлах байцаагчдыг сургагч багшаар ажиллуулах тухай саналыг 2023 оны 01/1059, 2024 оны 01/348 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Тус саналын дагуу 2024 оны 05 дугаар сарын 27, 28-ны өдрүүдэд Төрийн захиргааны төв байгууллагууд, Нийслэлийн Прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Нийслэлийн Хүний нөөцийн хөгжлийн төвтэй хамтран “Хяналтын улсын байцаагч нарыг мэргэшүүлэх сургалт”-ыг зохион байгуулж 7 агентлагийн нийт 76 улсын байцаагч хамрагдсанаас тус газраас 13 улсын байцаагч хамрагдаж гэрчилгээ авсан. Тус сургалтад газрын дарга С.Төмөрдулам нь “Хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах шаардлага” сэдвээр илтгэл тавьж мэдээлэл өгч ажилласан.



Зураг. Газрын даргын илтгэл



Зураг. Сургалтын гэрчилгээ гардуулж буй үйл явц

Төрийн албан хаагчдын ажлын үр дүнг сайжруулах, тэдгээрийн мэдлэг мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх зорилтын хүрээнд:

Албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх хүрээнд Нийслэлийн засаг даргын Тамгын газар Хүний нөөцийн хөгжлийн төв, бусад байгууллагуудаас танхимын болон онлайн хэлбэрээр зохион байгуулсан 11 сургалт, семинарт нийт 40 албан хаагчийг хамруулсан байна. Үүнд:


- Төрийн байгууллагын хүний нөөцийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт;
- Нийслэлийн Архивын газар болон Хэлний бодлогын үндэсний хүрээлэнтэй хамтарсан "Монгол бичгээр баримт бичгийг зохион бүрдүүлэх" тухай сургалт;
- Нийслэлийн Архивын газраас зохион байгуулсан "Хөтлөх хэргийн жагсаалт боловсруулах, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ын тухай сургалт;
- Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвөөс зохион байгуулсан дотоод хяналт шалгалт хариуцсан ажилтан, өргөдөл гомдлын шийдвэрлэлт хариуцсан ажилчдад зориулсан чиглүүлэх сургалт;
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн талаарх сургалт;
- Хүний эрхийн үндэсний комиссоос зохион байгуулсан "Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх" сургалт, хэлэлцүүлэг;

Хүний нөөцийн мэдээлэл	
Боловсролын түвшин, мэргэшсэн байдал	Мэргэжлийн ангилал
(Магистр-16, Баклавар-37) <ul style="list-style-type: none"> • Зөвлөх инженер-4, • Мэргэшсэн инженер-17 • Албан хаагчид хувиасаа төлдөг -400,0 төгрөг 	<ol style="list-style-type: none"> 1. Барилгын инженер-7 2. Архитектор -4 3. Ландшафтын архитектур-3 4. Хот төлөвлөлт-1 5. Авто замын инженер-1 6. Цахилгаанын инженер-4, 7. Дулааны инженер-3 8. Газрын тосны инженер-4 9. Геодезийн инженер-2 10. Сантехникийн инженер-1 11. Механик инженер-2 12. Барилгын материал технологи-2 13. Харилцаа, холбооны инженер-1 14. Тээврийн менежмент-1 15. Дотоод шаталтат хөдөлгүүр-1 16. Газар зохион байгуулалт-1 17.Мэдээллийн технологи-1 18.Төрийн удирдлага-3 19. Эрх зүй-1 20.Эдийн засаг-2 21. Нягтлан бодох бүртгэл-2
Нийт албан хаагчдын 70% архитектор, инженер мэргэжилтэй	

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс болон Хүний нөөцийн тасагт Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагад инженер, техникийн чиглэлээр ажилладаг албан хаагчдыг богино хугацааны (30 хүртэлх хоног), мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх 1-6 сарын сургалт (дунд хугацааны) гадаад сургалтад хамруулах судалгаанд тус газраас 16 албан хаагчийг хамруулахаар нэрсийг 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдөр хүргүүлсэн.

Монгол Улс, Япон Улсын Засгийн газар хоорондын гэрээгээр Монгол Улсын төрийн албаны хүний нөөцийг хөгжүүлэх JDS тэтгэлэгт хөтөлбөрт тус газрын Дотоод хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Э.Даваахатан тэнцэж Япон улсын Цүкүбагийн их сургуулийн Магистрт суралцах эрх авсан.

Тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд Төрийн албаны зөвлөл, JICE байгууллага, газрын удирдлагын гурван талт гэрээнд гарын үсэг зурах ёслолын ажиллагаанд Газрын дарга С.Төмөрдулам оролцлоо.



Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Удирдлагын академитай хамтран зохион байгуулж буй "Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны тухай хуулийн төсөл"-ийн талаарх хэлэлцүүлэгт тус газрын 4 албан хаагч оролцов.



Албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, батлуулах ажлын хүрээнд:

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны "Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны бүтэц, Нийслэл, дүүргийн Засаг даргын тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны орон тооны хязгаарыг батлах тухай" 81 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024

оны “Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийг өөрчлөн зохион байгуулах тухай” А/430 дугаар захирамж, “Хяналт шалгалтын газрын дүрэм шинэчлэн батлах тухай” А/654 дүгээр захирамжаар газрын бүтэц, орон тоо өөрчлөгдөж, дүрмээр хүлээсэн чиг үүрэгт өөрчлөлт орсонтой холбогдуулан Албан тушаалын ангилал, зэрэглэл батлах тухай тушаалыг А/16, А/10 дугаар тушаалаар 2 удаа шинэчлэн баталсан.

Төрийн албаны тухай хууль болон Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”, газрын шинэчлэгдсэн дүрэмд нийцүүлэн шинээр бий болсон хэлтэс, албан тушаалын тодорхойлолт боловсруулах, ажлын байрны шинжилгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг газрын даргын 2024 оны А/06 дугаар тушаалаар байгуулсан. Хэлтсүүдээс албан тушаалын тодорхойлолтын төслийг хүлээн авч хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлөөр 7 дугаар сарын 1-ний дотор хянуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Хяналтын улсын байцаагчийн эрх олгуулах, цуцлуулах ажлын хүрээнд:

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан "Хяналтын улсын байцаагчийн эрх олгох, цуцлах журам"-ын 4, 5 дугаар зүйл заалтын хүрээнд салбарын 5 Төрийн захиргааны төв байгууллага (яам)-тай хамтран ажиллаг байна.

- 1) Барилга, хот байгуулалтын яам;
- 2) Эрчим хүчний яам;
- 3) Зам тээвэр хөгжлийн яам;
- 4) Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам;
- 5) Цахим хөгжил харилцаа холбооны яам.

Хагас жилийн байдлаар хяналтын улсын байцаагчийн эрх олгуулах, цуцлуулах тамга, үнэмлэх шинээр хийлгэх саналыг Барилга, хот байгуулалтын яамны Салбарын хяналтын газарт 3 удаа , Эрчим хүчний яамны Салбарын хяналтын газарт 2 удаа, Зам, тээвэр хөгжлийн яамны Салбарын хяналтын газарт 3 удаа, Цахим хөгжил, харилцаа, холбооны яамны Салбарын хяналтын газарт 2 удаа, Уул, уурхай хүнд үйлдвэрийн яаманд 1 удаа, нийт **11** удаа хүргүүлж, холбогдох сайдын эрх олгосон тушаалыг үндэслэн албан тушаалд нь жинхлэн томилж ажиллалаа.



Албан хаагчдын цалин хөлс, зэрэг дэвийг нэмэгдүүлэх талаар хэрэгжүүлсэн ажлын хүрээнд:

Газрын даргын 2024 оны “Албан хаагчдын үндсэн цалин, нэмэгдлийг шинэчлэн тогтоох тухай” А/03, А/04 дүгээр тушаалаар албан хаагчдын цалин, хөлсийг 2 удаа шинэчлэн батлуулж батлагдсан хэм хэмжээг ТАЗ-ийн ХУМТЦС-д оруулан олгож байна. Мөн Төрийн үйлчилгээний цалингийн доод хэмжээг байгууллагын төсөвт багтаан шинэчлэн батлуулах, хоол, унааны нэмэгдлийг нэмэгдүүлэн батлуулах талаар удирдлагын зөвлөлийн 1 дүгээр хуралд танилцуулан дэмжигдэж төсвийн тодотгол батлагдсаны дараа олгож эхлэхээр төлөвлөгдөөд байна.

Хагас жилийн байдлаар тухайн албан тушаалд томилогдсон, албан тушаал өөрчлөгдсөн, шилжүүлсэн, нэр өөрчлөгдсөн 45 албан хаагч /ХБХГ-т шилжүүлсэн 18 албан хаагч/-ийн мэдээллийг ERP системд оруулах, бүртгэх, EDOC дэд системд албан бичиг, өргөдөл, гомдлыг хүлээн авах эрхийг нээж, зааварчилгаа өгч, бүртгэж баталгаажуулсан. Ингэхдээ 800 орчим үйлдлээр бүртгэж шинэчилсэн байна.

Төрийн жинхэнэ албаны болзол, шаардлага хангасан 27 албан хаагчийн зэрэг дэвийг нэмэгдлийг шинээр болон ахиулан олгуулах санал боловсруулж, 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 01/158 дугаар албан бичгээр Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлж, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох тухай” А/369 дүгээр захирамжаар албан хаагчдын зэргийн нэмэгдлийг олгуулсан.

Цаг бүртгэлийн тооцоо гаргах, цагийн бүртгэлтэй холбоотой хүсэлтийг шийдвэрлэх хүрээнд

Erp системээр ирүүлсэн нийт **2139** хүсэлтийг хүлээн авч учир шалтгаан, мэдэгдэлтэй танилцаж хавсарган ирүүлсэн материал, эмнэлгийн хуудас, үндэслэл зэргийг харгалзан удирдлага, хамаарах хэлтсийн дарга нараас тухай бүр тодруулан бүрэн тайлбар бичиж хүсэлтийг шийдвэрлэн цаг бүртгэлийн төлөвийг сайжруулан ажилласан.

Нийслэлийн Засаг даргын 2024 оны “Нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын ажлын цагийн хуваарьт зохицуулалт хийх тухай” А/630 дугаар захирамжийн дагуу 2024 оны 06 сарын 01-ний өдрөөс эхлэн байгууллагын нийт 52 албан хаагчийн цагийн бүртгэлийг өөрчлөн шинэчилж захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.



“НИЙСЛЭЛИЙН ТӨР, ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДЫН АЖЛЫН ЦАГИЙН ХУВААРЬТ ЗОХИЦУУЛАЛТ ХИЙХ ТУХАЙ”

Нийслэлийн Засаг даргын 2024.05.31-ний өдрийн А/630 дугаартай захирамж

ХУГАЦАА

06 сарын 01- 08 сарын 31 →



АЖИЛ ЭХЛЭХ, ДУУСАХ ЦАГ

07:00-16:00

09 сарын 01- 06 сарын 01 →



08:00-17:00

3.3. Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа

Байгууллагын 2024 оны архивын ажлын төлөвлөгөө гарган батлуулж, архивын баримт бичгийг зохих хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу хөтлөн явуулж, эмх цэгцийг хангуулан ажиллаж байна. 2023 онд үүсч, байгууллагын архивд хүлээн авсан цаасан баримт, хадгаламжийн нэгж тус бүрд баримт бичгийн нягтлан шалгалт хийж, стандартын алдаатай, хуудас буруу дугаарласан, дотоод товъёг буруу бичсэн зэрэг зөрчилтэй 58 хадгаламжийн нэгжийг буцаан өгч зөрчлийн арилгуулан засварлуулж авав.

Батлагдсан хуваарийн дагуу хэлтсүүдээс цаасан суурьтай 371 боть, цахим 11 баримтыг шалган хүлээн авч, үдэж хавтаслан хадгаламжийн нэгж үүсгэн архивд хүлээн авч данс бүртгэл үйлдэх ажлыг хуваарийн дагуу хийж дуусгасан. Үүнд:

- Байнга хадгалах 285 боть;
- Байгууллагад хадгалах 3 боть;
- Түр хадгалах 75 боть;
- 70 жил хадгалах 8 боть.



Газрын даргын баталсан 2023 оны А/01-А/77, Б/01-Б/110 тушаалыг ARCHIVE EDOC системд шивж оруулан, нягтлан шалгалт хийж нийслэлийн Архивын газрын Төрийн архивын хэлтсийн зааварагч-архивч Б.Адъяасүрэнгээр хянуулав.

Тушаал нэг бүрийн болон хадгаламжийн нэгж тус бүрээр скайнердсан цахим баримт үүсгэн office document-д байршуулж, DVD хуулж цахим хувийг нийслэлийн Архивын газрын Төрийн архивын санд хүлээлгэн өгөв.

ХУВЬСДӨЛӨН АЖИЛЧИН ГАЗАР
ТӨРИЙН АРХИВЫН ХАТГАЛ


ЗЭВЭЭРЭВЭНДЭХ ДЭЛЭГ БУЛГАМТ ХАТГАЛ АРСАН АКТ

2024 он-03 сарын өдөр 13

Хуульч: Б.А.А.А.А.

№	Бичлэг	Зүйл	Төрөл	Хуудас	Бичлэг	Бичлэг	Тайлбар
1.	Тусгай А	1	1	42	160	719 808	2023
2.	Тусгай А	1	1	292	111 180	1013	Сандагдан өгөгдсөн үйл
3.	Тусгай А	1	1	30	212	814 180	2023
4.	Тусгай Б	1	1	110	116	48 168	2023
Нийт	4	4	166	712	333 336	2023	

ХТӨСӨН ТӨРИЙН АРХИВЫН ХАТГАЛЫН ХАТГАЛ
ХТӨСӨН АРСАН
ХТӨСӨН ТӨРИЙН АРХИВЫН ХАТГАЛ
ХТӨСӨН ТӨРИЙН АРХИВЫН ХАТГАЛ



- Нийслэлийн Засаг даргын 2024 оны “Иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/91 дүгээр захирамжийн дагуу газрын даргын 2024 оны А/04 дүгээр тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж, газрын хэмжээнд сүүлийн 3 жилийн хугацаанд ирсэн өргөдөл, гомдлын бүртгэл мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийж, түүний дагуу шийдвэрлүүлэх арга хэмжээний саналыг нэгтгэн 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 02/159 дугаар албан бичгээр НЗДТГ-ын Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвд хүргүүлэв.
- Газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/18 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийн шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийсэн. Үр дүнг нэгтгэж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг газрын даргын зөвлөлийн хуралд 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдөр танилцуулж, нийт нэгж албан хаагчдад хүргүүлэхээр ажиллаж байна.
- Шийдвэрлэлтийн явцад зөрчил гаргасан 7 албан хаагчид дотоод журмын дагуу сануулах “Хяналтын шар хуудас” олгон арга хэмжээ авч ажилласан.
- Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд 7 хоног бүр дүн шинжилгээ хийж, тайлан мэдээг нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвд албан бичгээр нийт 24 удаа хүргүүлэв.

3.5. Шүүх хяналтын байгууллагад төлөөлөл хэрэгжүүлж ажилласан талаар

Хариуцсан чиг үүргийн хүрээнд Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд нийт 7 хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу тайлбар, нотлох баримтыг хүргүүлж хариуцагчаар оролцсон. Үүнээс 5 хэрэг эцэслэн шийдвэрлэгдсэн буюу шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон, хянан шийдвэрлэгдэх шатанд хэлэлцэгдэж байгаа 2 хэрэг байна. Шүүхийн шатанд байгаа хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдуулан нийт 13 удаа шүүх хуралд оролцсон байна. Одоогоор Нийслэлийн Засаг даргыг төлөөлж оролцох хэрэг гараагүй байна.

3.6. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ


Байгууллагын хэмжээнд Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах албан хаагчдын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хүлээн авах, хянах ажлын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллав. Үүнд:

- 2023 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг мэдүүлэх эрх бүхий албан хаагчдад хөрөнгө, орлогын мэдүүлгийг хэрхэн зөв бөглөх талаар заавар зөвлөмж өгч хөрөнгө орлогын мэдүүлгийг нийт 56 албан хаагчдаас хүлээн авч баталгаажуулан тайлан мэдээг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 02/169 дугаарын албан бичгээр хүргүүлсэн.
- 2024 оны хагас жилийн байдлаар шинээр нийтийн албанд томилогдсон эрх бүхий 7 албан хаагчдаас хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хүлээн авч баталгаажуулав.

- Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт дүн шинжилгээний хэлтэст шинээр болон албан тушаал дэвшиж нийтийн албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн нийт 7 албан хаагчдаас хувийн ашиг сонирхлын урьдчилан мэдүүлэгийг хүлээн авч хянаж баталгаажуулан холбогдох материалыг бүрдүүлэн хянуулахаар хүргүүлэн ажиллав.

Байгууллагын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 6 зорилтын хүрээнд 18 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн газрын даргаар батлуулсан. Төлөвлөгөөг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн ажиллав.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Авлигатай тэмцэх газраас авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэсэн тв шторк, нөлөөллийн аяны мэдээ, мэдээллийг байгууллагын албан ёсны цахим хуудсаар иргэд олон нийтэд тогтмол мэдээлэл хүргэн ажиллаж байна.



2023 оны Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг шинэчлэн гаргаж байгаатай холбогдуулан нийт албан хаагчдад "ХАСХОМ гаргахад анхаарах асуудал" сэдэвт сургалтыг 2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр зохион байгуулж арга зүйн зөвлөгөө өгч ажиллав.



3.7. Дотоод хяналт шалгалт, хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын талаар

Байгууллагын үйл ажиллагаанд 2024 онд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх календарчилсан төлөвлөгөөг гарган ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу газрын даргын 2024 оны А/15 дугаар тушаалаар батлагдсан “Угтах үйлчилгээ үзүүлэх тухай” удирдамжийн дагуу төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, үр дүнтэй хүргэх зорилгоор угтах үйлчилгээнд ажилласан албан хаагчдын илтгэх хуудас, гүйцэтгэх ажлын хүрээнд хийгдсэн ажил, иргэдэд мэдээлэл өгч буй үйл ажиллагаанд 2024 оны 03 дугаар сард хяналт тавьж, үр дүнг байгууллагын удирдах зөвлөлийн хуралд танилцуулан илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулав.

Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-д заасны дагуу албан хаагчдын “Өдөр тутмын ажлын тэмдэглэл” GoogleSheet хөтлөлтөд 2 удаа дотоод хяналт хийж, ажлын гүйцэтгэлийн тайлагналтыг сайжруулах чиглэлээр зөвлөмж боловсруулж нийт нэгжүүдэд хүргүүлэв.



ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ


4.1. Мэдээллийн ил тод байдал, хэвлэл мэдээлэл

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж, нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ын хэрэгжилтийг хангуулан газрын үйл ажиллагааны чиглэл, нийслэлээс баримталж буй бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн талаарх цаг үеийн нийт 362 удаагийн мэдээ, мэдээлэл бэлтгэн албан ёсны веб хуудас, пейж хуудсаар түгээж байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулж ажиллав. Үүнд:

- барилга, дэд бүтцийн төрийн хяналт шалгалтын чиглэлээр 78;
- барилга, байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааны чиглэлээр 5;
- хотын стандартын багц мэдээлэл, контент, видео шторк, сурталчилан таниулах ажлын талаар 220;
- бусад цаг үеийн мэдээ 59.

Байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээлийг олон нийтийн телевизээр 8 удаа, радиод 1 удаа, сонинд 1 удаа, мэдээллийн сайтад 1 удаа, Улаанбаатар мэдээ www.ulaanbaatar.mn-нд 10 удаагийн мэдээлэл бэлтгэн нийтлүүлж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр 30 яриа, 10 ярилцлага өгч нийт 308 удаагийн давтамжтайгаар цацагдсан байна.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж, нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ын хэрэгжилтийг хангуулан байгууллагын веб хуудас хуудсаар мэдээ мэдээллийг тухай бүр шинэчлэн байршуулж байна.



Газрын бүтэц, чиг үүрэг, нэр өөрчлөгдсөнтэй холбоотойгоор вебсайтыг www.inspection.ub.gov.mn домайн нэрд шилжүүлэх ажлыг эхлүүлж 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр “Үндэсний дата төв” УТҮГ-тай байгууллагын цахим шуудан, домэйн нэр олгох, мэдээллийн аюулгүй байдлын хяналттай холбоотой үйлчилгээний гэрээг байгуулав.

Нэг цэг угтах үйлчилгээ

Иргэд, олон нийтэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилгоор Нийслэлийн нутгийн Төр захиргааны цогцолбор байрны В1 давхарт Нэг цэгийн угтах үйлчилгээг ажиллуулж байна. Газрын даргын 2024 оны А/15 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах, “Нэг цэг” угтах үйлчилгээгээр төрийн үйлчилгээний мэдээллээр тасралтгүй хангах хүрээнд угтах үйлчилгээний хуваарийг нэгжийн дарга нараас санал авч газрын даргаар хянуулан баталгаажуулан албан хаагчдад танилцуулж, иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх талаар өдөр тутам арга зүйгээр ханган илтгэх хуудас, угтах үйлчилгээний тоог мэдээг нэгтгэн ажиллав.



Хандсан иргэний тоо – 599

Хүсэлтийн мэдээлэл, асуудлын агуулга чиглэлээр ангилбал:

1. Барилгын чанар, аюулгүй байдлыг шалгуулах - 250
2. Комиссын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл – 146
3. Батлагдсан стандартын хэрхэн хэрэглэх, яаж дагаж мөрдөх тухай – 185
4. Бусад – 18

4.2. Хүний нөөцийн ил тод байдал

Байгууллагын цахим хуудсанд төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2024 оны хөтөлбөр, сул орон тоонд сонгон шалгаруулалт зохион байгуулах 3 удаагийн зар мэдээлэл, төрийн байгууллага хооронд шилжүүлэн ажиллуулах 2 удаагийн зар мэдээлэл, шинэчлэгдсэн бүтцийн танилцуулга, орон тоо зэрэг нийт 11 төрлийн дата мэдээллийг тус тус байршуулан байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангуулсан.



4.3. Төсөв, санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдал

Нийслэлийн Дотоод аудитын албанд 2020-2022 онуудын санхүүгийн болон шаардсан баримтуудыг хүлээлгэн өгч явцын аудитын шалгалтад хамрагдаж, 2024 оны “Хангалттай” гэсэн дүгнэлтийг авсан. Нийслэл дэх Төрийн аудитын газарт 2024 оны 1 дүгээр сарын 23-ний өдрийн 01/89 дугаар бичгээр байгууллагын 2023 оны санхүүгийн тайланг хүргүүлж, аудит хийлгэн, 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 168 дугаар Аудитын дүгнэлтээр “Өөрчлөлтгүй” дүгнэлтийг хүлээн авч ажиллалаа.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогчид хүргүүлэн хянуулан ажиллаж, 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар байгууллагын батлагдсан төсвийн гүйцэтгэл 73.4 хувийн хэрэгжилттэй байна.

Байгууллагын хэмжээнд зайлшгүй шаардлагатай байгаа компьютер тоног төхөөрөмж, тавилга эд хогшлын шинэчлэх санал боловсруулан 2024 оны төсвийн тодотголд тусгуулахаар 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн “Хүсэлт хүргүүлэх тухай” 01/109 албан бичгийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү хөрөнгө оруулалтын газарт хүргүүлсэн. Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/569 дугаар захирамжаар газрын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн баталсантай холбогдуулан батлагдсан орон тоогоор цалингийн төсвийн саналыг хүргүүлж, төсвийн хуваарьт тусгуулан ажиллав.

4.4. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллах хүрээнд <https://shilendans.gov.mn/> системд 2023 оны 4 дүгээр улирлын тайлан болон тухайн жилд байршуулсан мэдээллийг 2024 оны 02 дугаар сарын 16-ний өдрийн 01/156 дугаар албан бичгээр нийслэлийн Дотоод аудитын албанд хүргүүлэв.

Шилэн дансны цахим системд санхүүгийн холбогдох мэдээлэл, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл болон барилга байгууламжийг ашиглалтад оруулах болон их засвар, тохижилтын ажлыг хүлээн авах комиссын бүрэлдэхүүнд ажилласан албан хаагчдын мэдээллийг сар бүр хугацаанд нь тайлагнаж, байгууллагаас оруулах нийт 70 мэдээллээс хугацаандаа-69, хугацаа хоцроосон- 1, нийт гүйцэтгэл 98.65 хувьтай байна.

The screenshot shows the 'Shilendans' web portal interface. At the top, there are navigation tabs for 'Хөтөн стандарт хяналтын газар (8314551)' and 'Байгууллагын хэрэглэгч'. The main content area displays 'Хэрэглэгчийн мэдээллийн хяналт' with four summary cards: 'Нийт мэдээлэл' (12), 'Хугацаандаа Мэдээлсэн' (5), 'Хугацаа хоцорч мэдээлсэн' (0), and 'Мэдээлээгүй' (7). Below this is a table with columns for '№', 'Тайлангийн нэр', 'Мэдээллийн төрөл', 'Мэдээлэл оруулах хугацаа', 'Тайлан оруулах хэрэглэгч', 'Зөвөл эсэх', and 12 numbered columns for status. The first row shows a report titled 'Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөвс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдээгдэл' with a status of 'СОХБААТАР БОЛДОО' and a green checkmark in the 4th column.

ТАВ. БУСАД МЭДЭЭЛЭЛ

5.1. Цаг үеийн шинжтэй олон нийтийн ажлын талаар

1. Байгууллагын албан хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, нийтийн биеийн тамрын хөгжүүлэхэд албан хаагчдын идэвх оролцоог нэмэгдүүлэх зорилгоор байгууллагын аварга шалгаруулах "Standart cup" 5 төрөл (сагсан бөмбөг, гар бөмбөг, шатар, дартс, шинээний теннис)-т спорт арга хэмжээг байгууллагын дэргэдэх Биеийн тамир, спорт хамтлагийн зүгээс 2024 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр амжилттай зохион байгуулсан. Тэмцээний нийлбэр дүнгээр О.Одjarгал ахлагчтай Хязгааргүй баг тэргүүлж "Байгууллагын аварга" цомын эзэн боллоо.





2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний ажлын хүрээнд “НОГООН ХОТ-ИРГЭНИЙ ОРОЛЦОО” уриатай Баянзүрх дүүргийн 28 дугаар хороо, Олон улсын эко цэцэрлэгт хүрээлэн “IGM” -ийн талбайн тодорхой байршилд хаврын мод тарих аянд нэгдсэн.



3. Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/348 дугаар захирамж, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас баталсан удирдамжийн дагуу нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдсан “Хотоо угаая” уриатай хаврын их цэвэрлэгээнд 2024 оны дөрөвдүгээр сарын 12-ний өдөр оролцож, Соёлын төв өргөөний арын зам, Ерөнхий сайд Амарын гудамжны баруун уулзвараас зүүн уулзвар хүртэл нийтийн эзэмшлийн 310 метр талбайг угааж цэвэрлэв.



4. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас баталсан удирдамж, хуваарийн дагуу 90' минутын цэвэрлэгээ арга хэмжээнд 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр оролцож, “Энхтайвангийн гүүр”-ээс баруун тийш Нарны гүүр хүртэлх Дунд голын хойд хэсгийн хогийг түүж цэвэрлэв.



5. Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдын дунд 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулсан танин мэдэхүйн хөгжөөнт UB QUIZ-385 тэмцээнд 2 багийн бүрэлдэхүүнтэй оролцов.



6. “Улаанбаатар Марафон-2024” олон улсын гүйлтийн тэмцээн 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдөр Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулагдаж тус газраас 5км, 21км төрөлд тус тус амжилттай оролцлоо.



7. Монгол Улсын Засгийн газар, Жендэрийн үндэсний хорооноос үндэсний хэмжээнд “Харилцан хүндэтгэе” аян өрнүүлсэн. Тус аяны хүрээнд Хувь хүний хөгжлийн институт ТББ болон байгууллагын дэргэдэх Хүний эрх, жендэрийн зөвлөлтэй хамтран “Харилцаа ба эерэг харилцаа” сэдвээр нийт албан хаагчдыг хамруулан сургалт зохион байгуулав.



ЗУРГАА. ДҮГНЭЛТ, САНАЛ

Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг сайжруулах үндсэн зорилгын дор Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хяналт шалгалтын газар шинээр өөрчлөн зохион байгуулагдаж, төрийн хяналтын чиглэлээр дагнасан чиг үүргийг хэрэгжүүлж нийслэлийн удирдлагын үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэж эхлээд байна.

Тус газар нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай байгуулсан 2024 оны хариуцлагын гэрээний эхний хагас жилийн биелэлт 97.02 хувь, байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө 91.1 хувийн хэрэгжилттэй ажиллаж, 2024 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 01/251 тоот албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тайлагнасан байна.

Хариуцлагын гэрээ, гүйцэтгэлийн тайлангийн биелэлт хэвийн түвшинд байх боловч үндсэн чиг үүргийн хэрэгжилттэй холбоотой дараах нийтлэг асуудлууд бий болж байна. Үүнд:

- 2023-2024 онд тус газрын хариуцсан хяналтын чиглэлтэй холбоотой иргэдийн өргөдөл гомдол, зөрчлийн тоо төдийлөн буурахгүй, ажлын ачаалал нэмэгдэж байгаагаас үзвэл Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль болон салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт болон хяналт шалгалтын үр нөлөөг сайжруулахын тулд хууль эрх зүй, хүний нөөц, төсөв санхүүгийн талаас дорвитой арга хэмжээг санаачлан хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна.
- Барилга дэд бүтцийн салбарын хяналтын улсын байцаагч нарын ажлын ачаалал харилцан адилгүй, хүний нөөцийн дутагдалтай байна.
- Нийслэлийн Прокурорын газрын шаардлагад дурдагдсанаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд техникийн алдаа, дутагдлууд нийтлэг илэрч байгаа нь эрх бүхий албан тушаалтнуудын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх хэрэгтэй байгааг илтгэж байна.

Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ:

Захиргаа, дотоод хяналтын хүрээнд:

- Үндсэн чиг үүргийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавих тогтолцоог бүрдүүлж, хэвшүүлэх,
- Албан хаагчдын ажлын ачаалал, дотоод ажлын чиг үүргийн хуваарилалтыг оновчтой зохион байгуулах
- Удирдлагын мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх,
- Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах,
- Албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлыг үе шаттай зохион байгуулах

Хүний нөөцийн үйл ажиллагааны хүрээнд:

- Албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулах;
- Сул орон тоог нөхөх, сонгон шалгаруулалтыг зохион байгуулах;
- Албан хаагчид, улсын байцаагч нарыг дадлагажуулах, мэдлэг ур чадварыг сайжруулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх

Хяналт шалгалтын үр нөлөөг сайжруулах хүрээнд

- Хяналт шалгалтад шаардлагатай баталгаат, үнэн зөв мэдээллийн эх үүсвэр, хүртээмжийг нэмэгдүүлэх
- Хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн тогтолцоог сайжруулах
- Зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагаанд гарч буй нийтлэг зөрчил, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсэд дүн шинжилгээ хийж, зөрчлийг бууруулах ажлыг үе шаттай төлөвлөх
- Эрх бүхий албан тушаалтнуудыг тогтсон хугацаанд сургах, дадлагажуулах тусгайлсан хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх
- Хяналт шалгалтын уялдаа холбоог сайжруулах бүртгэлийн системийн хөгжүүлэлтийг хийж, үйл ажиллагаанд нэвтрүүлэх;
- Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл гомдол, хүсэлтэд дүн шинжилгээ хийж, бууруулах арга хэмжээг авч ажиллан, орчны эрсдлийг бууруулж ажиллах;
- Төрийн хяналт шалгалтын үр дүнд суурилсан зөрчлийг бууруулах урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллах.

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах чиг үүргийн хүрээнд

- Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг төлбөртэй үйлчилгээ болгох, барилга ашиглалтад оруулах дүгнэлтийг үнэт цаасаар хэвлэх;
- Комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгавар болон биелэлтийн баримт нотолгоо бүхий мэдээллийн ил тод байдлыг хангуулж, нэгдсэн цахим системд шилжүүлэх;